

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

2019 оны жилийн эцэс

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль							
1	1	Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2013-02-07 Дугаар 2013_05	39.12. 39.12.Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.	Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмын төслийг боловсруулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд-ын Ерөнхий боловсролын бодлогын газар, Сургуулийн өмнөх боловсролын газар, Хуулийн хэлтэс болон холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулж саналыг авсан. Мөн журмын төслийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны цахим хуудсанд http://www.mecss.gov.mn/forum180109 олон нийтэд хэлэлцүүлэхээр байршуулж, орон нутгийн боловсрол, соёл урлагийн газруудад журмын төсөл болон танилцуулгыг нэгж байгууллагуудаас болон холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авч боловсруулсан. Үндэслэж буй хуулийн заалтад “Төрийн өмчийн” гэж заасан бөгөөд Боловсролын салбарын 2017-2018 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр төрийн 878 цэцэрлэг, 652 сургууль байгаагийн 7 сургууль нь буюу төрийн өмчийн, үлдсэн нь орон нутгийн өмчийн сургууль,	100%	100%	

				цэцэрлэг байдаг. Иймд журмыг боловсруулахдаа “төрийн болон орон нутгийн өмчийн” гэж хамрах хүрээг өргөжүүлсэн. Нэмэлт орлогод тооцох орлогууд, түүнийг зарцуулах зориулалт зэргийг салбарын онцлогийг харгалзан тусгасан. Журмын төслийг Сангийн яаманд хүргүүлсэн. Сангийн яам тусгайлан журам гаргах шаардлагагүй гэж үзэн Төсвийн тухай хуулийг баримтлан Сангийн сайдын тушаалаар улсын төсвийн бүх байгууллага дагаж мөрдөн нийтлэг журам гаргахаар шийдвэрлэсэн болно. Үүнд: Нэмэлт орлогыг төлөвлөх, зарцуулах, тайлагнах, бүртгэх зэрэг үйл ажиллагааг Төрийн сангаар дамжуулан Сангийн сайдын баталсан нийтлэг журмыг баримтлахаар тусгасан. Монгол Улсын Төсвийн тухай хууль 47 дугаар зүйлийн 47.1 болон 47.1.5 дахь заалтын дагуу Сангийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 216 тоот тушаал, 2019 оны 74 дүгээр тушаалаар шинэчилж “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг баталсан. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд Сангийн сайдын баталсан журмыг дагаж мөрдөж			
2	2	Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай 2013-02-07	8.15. Сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа байгууллагын нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог боловсролын нийгмийн хамгааллын, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн	Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9.9 дэх хэсэгт Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно гэж заасан. 2019-2020 оны хичээлийн жилд урьдчилсан байдлаар тусгай 4 цэцэрлэгт 252,	70%	70%	

		Дугаар 2013_06	захиргааны төв байгууллага хамтран тогтооно.	ердийн цэцэрлэгийн тусгай бүлэгт 159, ердийн 280 цэцэрлэгийн 488 бүлэгт 665 хүүхэд, нийт 1076 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна. Хамран сургалт 57.2 хувьтай байна.			
3	3	Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2013-02-07 Дугаар 2013_07	13.8. Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоог боловсролын, нийгмийн хамгааллын, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.	Ерөнхий боловсролын сургуульд 2018-2019 оны хичээлийн жилд 6518 суралцагч суралцаж байгаагаас ердийн хэв шинжийн ерөнхий боловсролын сургуульд 4778 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг өөрийн оршин суух газартаа хамт олонд түшиглэн хөгжүүлэх үзэл баримтлалыг дэмжиж, тухайн хүүхэдтэй ажиллаж байгаа багшид нэмэгдэл хөлс олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгон Засгийн газрын 2019 оны 145 дугаар тогтоолоор тогтоолоор “хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа ердийн сургууль, цэцэрлэгийн багшид 2019 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн урамшил олгох асуудлыг судалж шийдвэрлэх,” гэж баталсан.Энэ дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсах зардалд 12.0 тэрбум төгрөг, үүнээс 5.0 тэрбум төгрөгийг багш нарт урамшуулал болгон олгохоор төсвийн төсөлд тусгасан. Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид үндсэн цалингийн 10 хувийн урамшил олгохоор тогтоолын төсөл боловсруулан ХНХЯ-нд хүргүүллээ.	100%	100%	
	4		13.9. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн боловсролын үнэлгээний журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын	2019 онд “Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн хэрэглэгдэхүүн” 2019 он, “Суралцахуйн хоцрогдолтой, зан үйлийн эмгэгтэй хүүхдэд	100%	100%	

			гишүүн батална.	дэмжлэг үзүүлэх арга зүй, хэрэглэгдэхүүн” 2019 он, “Дохионы хэлээр харилцаж сурцгаая” Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан багц карт 2019 он, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үгийн нөөц нэмэгдүүлэх хэл ярианы дутмагшилтай хүүхдэд зориулсан “Зурган таних тэмдгийн эмхтгэл” -ийг 144.886.000 төгрөгөөр 29.700 ширхэг хэвлэн улс бүх сургууль, насан туршийн боловсролын төвүүдэд хүргүүллээ. Мөн шинээр “Айзамт хөдөлгөөнт дасгал” хичээлийн багшийн ном, “Яриа бичиг” хичээлийн багшийн ном, “Биет зүйл” хичээлийн багшийн номыг боловсруулан гаргасан.			
4	5	Соёлын өвийг хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/ 2014-05-15 Дугаар 2014.05.15	9.1. Соёлын биет өвийн үнэлгээ хийх журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	Журмын шинэчилсэн төслийг боловсруулж бэлтгэсэн. Соёлын биет өвийг үнэлэх асуудал хууль хооронд зөрчилтэй байгаа тул Хөрөнгийн үнэлгээний хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, Соёлын тухай хуулийг дагуулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Холбогдох хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулж хууль хоорондын зөрчил, давхардлыг арилгасны дараа журмыг батлуулна.	70%	70%	
	6		35.1. Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Журмын шинэчилсэн төслийг боловсруулж бэлтгэсэн. Соёлын биет өвийг үнэлэх асуудал хууль хооронд зөрчилтэй байгаа тул Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, Соёлын тухай хуулийг дагуулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Холбогдох хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулж хууль хоорондын зөрчил, давхардлыг арилгасны дараа журмыг батлуулна.	70%	70%	

7		46.2. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөл ажиллана. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална	Журмын төслийг боловсруулж бэлтгэсэн. Зөвлөлийн чиг үүрэг Төрийн хяналт шалгалтын тухай хуультай зөрчилдөж байгаа тул Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зөрчлийг арилгах заалтыг тусгасан. Холбогдох хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулж хууль хоорондын зөрчил, давхардлыг арилгасны дараа батлуулна.	70%	70%	
8		47.2. Соёлын биет өвийг сэргээн засварлах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	Журмын төслүүдийг боловсруулж бэлтгэсэн. Соёлын биет өвийг сэргээн засварлах мэргэжлийн зөвлөлийн чиг үүрэг Төрийн хяналт шалгалтын тухай хуультай зөрчилдөж байгаа тул Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зөрчлийг арилгах заалтыг тусгасан. Дээрх зөвлөлийн үйл ажиллагааны гол чиглэл барилга, архитектурын дурсгалтай холбоотой тул журмуудыг уялдуулах зорилгоор хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулж хууль хоорондын зөрчил, давхардлыг арилгасны дараа батлуулна.	30%	30%	
9		52.2. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журмыг соёлын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	БСШУС-ын сайд, Сангийн сайдын 2019 оны А/237/92 дугаар тушаалаар "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам" батлагдсан.	100%	100%	

	10		54.3. 54.3.Улс, орон нутгийн музей болон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, борлуулагч нь мерчандайзийн гэрээ байгуулна. Гэрээний загварыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Гэрээний төслийг боловсруулах явцад гэрээний загвар батлагдсаны дараа гэрээнд оролцогч талууд оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулаагүй эрх зүйн үр дагавар үүсэх нөхцөл бүрдсэн тул Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, Соёлын тухай хуулийг хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.	30%	30%	
	11		40.4.. Зөрчлийн тухай мэдээллийг худалдан авах журмыг Засгийн газар батална. Мэдээллийн нууцлалыг хууль тогтоомжийн дагуу чандлан хадгална.	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2017 оны А-297, 360 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишиг”-т “Эрэн сурвалжлагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл, бусад эд зүйлсийн тухай мэдээлэл”-ийн 2 сая хүртэл төгрөгөөр худалдан авахаар туссан. Иймд Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд 40.4 дэх заалтыг хасах саналыг боловсруулж, Соёлын тухай хуулийг дагуулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.	70%	70%	
5	12	Номын сангийн тухай 2014-12-19 Дугаар 2014.12.19	22.2. Номын сангийн сан хөмрөгт байхгүй, түүх болон судалгаа, шинжилгээний ач холбогдол бүхий ном, судрыг нөхөн бүрдүүлнэ. Нөхөн бүрдүүлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ШУА-ийн Хэл, зохиол болон түүх, археологийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж журмын төсөлд саналыг тусгасан. Тус журмыг 2020 онд батлуулахаар төлөвлөсөн болно.	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	
	13		24.3.. Хувийн номын сангийн	Үндэсний номын сангийн мэргэжлийн	70%	70%	

			сан хөмрөгт чухал ач холбогдол бүхий ганц хувь бүтээл байгаа тохиолдолд тухайн номын санд дэмжлэг үзүүлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	зөвлөлийн 11 дүгээр сарын хурлаар хэлэлцүүлж саналыг тусгасан. Журмын төсөлд үр нөлөөний болон тандалт судалгаа хийсэн. Журмын төслийг эцэслэн боловсруулж Хуулийн хэлтсээр хянуулан, яамны удирдлагуудад танилцуулж, батлуулахаар ажиллаж байна.			
	14		25.2. Улсын болон орон нутгийн номын сангийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Журмын төслийг боловсруулах гадаад болон дотоодын ажлын хүрээнд бүх төрлийн номын санд үзүүлж буй төлбөрт үйлчилгээний дүрэм, тарифыг судалж байна. Тус журмыг 2021 онд батлуулахаар төлөвлөсөн болно.	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	
6	15	Хууль тогтоомжийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-05-29 Дугаар 2017.01.01	30.3. Хууль зүйн хэлний салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А7/А9 хамтарсан тушаалаар Хууль зүйн хэлний салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлан хэрэгжүүлж байна. Хууль зүйн хэлний салбар зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасан чиг үүргийн хүрээнд тодорхойлсон.	100%	100%	
7	16	Галын аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-07-02 Дугаар 2015.07.02	7.5.. Боловсролын салбарт хэрэгжүүлэх гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсролын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, хэрэгжүүлнэ.	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал болон гамшиг, онцгой байдлын үеийн үйл ажиллагааг сайжруулахын тулд “Ерөнхий боловсролын сургуулийн орчныг аюулгүй байдлыг хангах дунд хугацааны төлөвлөгөө” /2017-2020 он/-ний төсөлд Барилга хот байгуулалтын яам, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан, Японы хүүхдийг	100%	100%	

				ивээх сан, Монголын Улаан загалмайн нийгэмлэг, Дэлхийн зөн-Монгол олон улсын байгууллага, Жайка олон улсын байгууллагаас санал авч эцэслэн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/398 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2018 оны А/181 дүгээр тушаалаар “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж эхлээд байна. Хөтөлбөрийг ОБЕГ болон олон улсын байгууллагын мэргэжлийн төлөөллийг оролцуулан хамтран боловсруулсан. Тус хөтөлбөрийг сургалтын цөм хөтөлбөртэй уялдуулж, засан сайжруулах ажил хийгдэж байна. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх дээд боловсролын сургалтын байгууллагууд авч хэрэгжүүлдэг. Галаас хамгаалах шалгуур, шаардлагын дагуу сургууль бүрт галаас хамгаалах булан ажиллуулж шаардлагыг ханган ажиллаж байна.			
8	17	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай 2015-11-26 Дугаар 2015.11.26	7.5. 7.5.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	Монгол Улсын “тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2016-2017 оны жилийн эцэс болон 2018 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Сангийн яаманд хүргүүлсэн	100%	100%	

	18		22.2.. Төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын бодлогын залгамж чанарыг хадгалах зорилгоор өмнө хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг нэгтгэсэн эмхэтгэлийг жил бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэвлэн нийтэлнэ.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 22.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны цахим хуудсыг шинэчлэн, “Бодлого төлөвлөлт”, “Тайлан мэдээ” гэсэн бүлэг шинээр бий болгож, бүхий бодлого төлөвлөлт, тайлан мэдээг мэдээллийг нэгтгэн, олон нийтэд ил тод мэдээлж байна. Жил бүр боловсролын салбарын статистикийн мэдээллийн эмхтгэлийг нэгтгэн гаргадаг.	100%	100%	
9	19	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай 2016-02-05 Дугаар 16-04	12.2.. Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг боловсролын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	"Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журам"-ын төслийг боловсруулсан. Хэлмэрч орчуулагчийн эрх олгох ажлыг чиг үүргийн хувьд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар олгох тул санал авахаар хүргүүлээд байна. Энэхүү журмын зорилго нь монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулж, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг хэлмэрчилж, орчуулах үйл ажиллагаанд мөрдөгдөнө. “Дохионы хэлний хэлмэрч, орчуулагч” гэсэн мэргэжлийн нэршил “Монгол улсын үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт”-д бүртгэх ажил хүлээгдэж байгаа тул баталгаажаагүй болно.	100%	100%	
	20		13.2.. Брайль үсгийн стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг	Брайль үсгийн стандартын төслийг боловсруулан Стандарт хэмжилзүйн газрын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Эрүүл мэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээний стандартчиллын техникийн хороогоор	100%	100%	

		үндэслэн стандартчиллын төв байгууллага батална.	хэлэлцүүлэн гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдэн 2019 оны СХЗГ-ын даргын С/58 тоот тушаалаар "Монгол брайль бичгийн стандарт" MNS6800:2019 батлагдсан. Энэ стандарт батлагдсанаар хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд бусад хүмүүсийн нэгэн адил тэгш оролцох, бусад хүмүүс харааны бэрхшээлтэй иргэдтэй брайль үсгээр дамжуулан харилцах, бие биедээ туслах, харилцан суралцах боломж бүрдэж, харилцааны чухал хэрэглүүр болох юм. Багш нарт брайль үсгийн анхан шатны мэдлэг олгох, насан туршийн боловсролын төвөөр дамжуулан бичиг үсэг тайлагдаагүй харааны бэрхшээлтэй хүнд бичиг үсэг заах зэрэг ажлуудыг хэрэгжүүлнэ.			
21	14.5.. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх, бүх шатны боловсрол олгох үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газар батална.	Энэхүү төлөвлөгөөний 2.1.2-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 145 дугаар тогтоол гарсан.2.1.3-д "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах арга, аргачлал" батлагдсан. 2.1.4-Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 933 хүүхдэд явуулын багшийн үйлчилгээ үзүүлсэн. 2.1.6 - "Чанарын үнэлгээний журам"-д хүүхдийн ахицаар нь үнэлэх заалтууд орсон. 2.1.8-Багш мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын сонгон судлах хичээлд "Тусгай хэрэгцээт боловсрол" хичээлийг оруулж 600 гаруй оюутан сонгон судалсан байна. 2.1.9-Монгол дохионы хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа явуулах журам"-ыг боловсруулсан.2.1.10-2019 оны 12 дугаар 03-нд "Монгол брайль үсгийн стандарт" батлагдлаа. 2.2.5- Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн хэрэглэгдэхүүн	100%	100%		

			боловсруулан 803 сургууль, бүх насан туршийн боловсролын төвүүдэд хүргүүлсэн. 2.2.2-.2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн БСШУС-ын сайдын А/173 тоот тушаалаар “Багш нарт зориулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, нөхөн сэргээх, ахуйн баримжаа олгох сургалтын модуль Боловсролын хүрээлэн боловсруулан 2 удаагийн сургалтаар 100 багшийг хамрууллаа.			
22		15.8.. Энэ хуулийн 15.6-д заасан сургалтын зардлын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.	Элсэлтийн шалгалтад тэнцэж дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг 2018-2019 оны хичээлийн жилийн бакалаврын хөтөлбөрт нийт 6247 оюутан суралцаж, 8,171,465,879 төгрөгийн буцалтгүй тусламж олгож байна.	100%	100%	
23		15.2.. Бүх шатны сургалтын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	"Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам"-ыг боловсруулсан. Журмын төслийг Японы Хүүхдийг Ивээх Сангийн “Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийн техникийн зөвлөлийн хурал, удирдах зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлжээ. Мөн ХНХЯ-ны сар бүр зохион байгуулдаг Төрийн бус байгууллагуудын мэдээллийн хурлаар хэлэлцүүлэн эцэслэсэн.	70%	70%	
24		15.3.. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын асуудал	Нийслэлийн 10, 186 дугаар тусгай цэцэрлэгүүдэд Эрт оролцооны “Портеж” сургалтын хөтөлбөрийг туршин хэрэгжүүлж байна. ЖАЙКА (JICA) -ын "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл	100%	100%	

		эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	<p>мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл" нь Японы 20 гаруй жилийн эмнэлзүйн туршлага, судалгаа шинжилгээний үр дүнг үндэслэн боловсруулсан "Шинэ хувилбар-Портеж эрт боловсролын хөтөлбөр"-ийн Монгол хувилбарыг гаргахаар ажиллаж байна. Энэ зорилтын хүрээнд 2016 оны 9 дүгээр сараас Монголын Аутизмын холбоо, Дауны Холбоотой хамтран Портеж хөтөлбөрийг туршиж байна. Энэ хөтөлбөр нь хүүхдийн хөгжлийг магадлан шалгах хуудас, хөгжлийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны зааварчилгаа, гарын авлага, хөгжлийн явцыг тэмдэглэх хүснэгт зэргээс бүрдэнэ.</p> <p>Хөтөлбөрийн онцлог: Эцэг эх, гэр бүлийн гишүүд нь гэр орондоо хүүхдэд тогтмол сургалт явуулах боломжтой. Сургалтад тусгай байр, нөхцөл байдал, хэрэглэгдэхүүн шаарддаг хөтөлбөр биш юм. Мөн хэвийн хөгжилтэй хүүхдийн хөгжлийн үе шат, хөгжих явцыг зорилтот хүүхдийнхээ нөхцөл байдалд харьцуулж нийцүүлэн хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулж болох давуу талтай. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зохих түвшний боловсрол эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тухайн хүүхдийн хөгжлийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан мөрдөж байна.</p> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 08 дугаар сарын 06-ний өдрийн А/491 тоот тушаалаар "Ерөнхий боловсролын оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө", "Оюуны хөгжлийн бэрхшээлтэй ахлах ангийн сургуулийн сургалтын төлөвлөгөө", "Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын</p>			
--	--	---	---	--	--	--

			төлөвлөгөө", "Харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө"-г тус тус шинэчлэн баталсан.			
25		15.9.. Энэ хуулийн 15.7-д заасан ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалт, зардлын хэмжээ, олгох журмыг боловсрол болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	2019 онд "Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн хэрэглэгдэхүүн" 2019 он, "Суралцахуйн хоцрогдолтой, зан үйлийн эмгэгтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүй, хэрэглэгдэхүүн" 2019 он, "Дохионы хэлээр харилцаж сурцгаая" Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан багц карт 2019 он, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үгийн нөөц нэмэгдүүлэх хэл ярианы дутмагшилтай хүүхдэд зориулсан "Зурган таних тэмдгийн эмхтгэл"-ийг 144.886.000 төгрөгөөр 29.700 ширхэг хэвлэн улс бүх сургууль, насан туршийн боловсролын төвүүдэд хүргүүллээ. Мөн шинээр "Айзамт хөдөлгөөнт дасгал" хичээлийн багшийн ном, "Яриа бичиг" хичээлийн багшийн ном, "Биет зүйл" хичээлийн багшийн номыг боловсруулан гаргасан. Дахин хэвлэлтээр 9 төрлийн сурах бичгийг хэвлэсэн байна. "Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам"-ыг боловсруулсан. Журмын төслийг " Японы Хүүхдийг Ивээх Сангийн "Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь" төслийн техникийн зөвлөлийн хурал, удирдах зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлжээ. Мөн ХНХЯ-ны сар бүр зохион байгуулдаг Төрийн бус байгууллагуудын мэдээллийн хурлаар хэлэлцүүлэн эцэслэсэн.	70%	70%	

10	26	<p>БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 2016-04-14 Дугаар 16-04</p>	<p>“9.5.. Гадаад улсын боловсролын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэх, багц цаг харилцан тооцох асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.”</p>	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/156 дугаар тушаалаар “Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам”-ыг батлан хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү журмаар гадаад улсад суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэний баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэн тооцох асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан шийдвэрлэхээр тусгасан. УИХ-д өргөн барьсан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “Гадаад улсын боловсролын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэх, багц цаг, олон улс, хөгжингүй орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг ерөнхий боловсролын хөтөлбөрийн шалгалтын оноог зөвшөөрч, харилцан тооцох асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.” гэсэн заалт нэмж оруулахаар тусгаад байна. Мөн Оюутан элсүүлэх журамд энэ талаар нэмэлт оруулахаар төсөлд тусгаад байна. ОХУ-д 5 жилээс дээш мэргэжилтнээр суралцсан төгсөгчдийн боловсролын баримт бичгийн магистрийн зэргтэй дүйцүүлэх тухай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/229 дүгээр тушаал гарсны дагуу иргэдийн хүсэлтийг хүлээн авч одоогийн байдлаар 100 гаруй хүний асуудлыг шийдвэрлээд байна. Монгол Улс нь ОХУ, БНХАУ, Турк, Австри, Куба, Украин, Лаос, Польш улстай боловсролын баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай баримт</p>	100%	100%	
----	----	--	--	---	------	------	--

				бичгүүдийг Засгийн газрын түвшинд байгуулсан байдаг. Боловсролын баримт бичиг, эрдмийн зэрэг, цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг байгуулах чиглэлээр ажиллаж байна. Дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай Ази, Номхон далайн бүс нутгийн 2011 оны Токиогийн конвенцид нэгдэж Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 399 дүгээр тогтоолоор "Дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай Ази, Номхон			
	27		18.5.. Энэ хуулийн 3.1.19-т заасан үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/582 дугаар тушаалаар “Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага”-ын төсөл боловсруулах ажлын хэсгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, холбоодын төлөөллийг оролцуулан байгуулж, “Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага”-ын төслийг боловсруулж, хэлэлцүүлсний дүнд саналыг тусган батлуулахаар ажиллаж байна.	70%	70%	
11	28	ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 2016-04-14 Дугаар 16-04	4.5.. Дээд боловсролын зэрэг олгодог онолын мэдлэг, ур чадвар, дадал бүхий үйлдвэрийн инженер, технологичийг бэлтгэх технологийн коллеж байх бөгөөд технологийн коллежийн хөтөлбөрийн агуулга, багц цагийн хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны	Энэхүү төлөвлөгөөний 2.1.2-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 145 дугаар тогтоол гарсан.2.1.3-д "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах арга, аргачлал" батлагдсан. 2.1.4-Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 933 хүүхдэд явуулын багшийн үйлчилгээ үзүүлсэн. 2.1.6 - "Чанарын үнэлгээний журам"-д хүүхдийн ахицаар нь үнэлэх заалтууд орсон. 2.1.8-Багш мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын сонгон судлах хичээлд "Тусгай хэрэгцээт боловсрол"	100%	100%	

			төв байгууллага тогтооно.”	хичээлийг оруулж 600 гаруй оюутан сонгон судалсан байна. 2.1.9-Монгол дохионы хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа явуулах журам"-ыг боловсруулсан.2.1.10-2019 оны 12 дугаар 03-нд "Монгол брайль үсгийн стандарт" батлагдлаа. 2.2.5- Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн хэрэглэгдэхүүн боловсруулан 803 сургууль, бүх насан туршийн боловсролын төвүүдэд хүргүүлсэн. 2.2.2-.2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн БСШУС-ын сайдын А/173 тоот тушаалаар “Багш нарт зориулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, нөхөн сэргээх, ахуйн баримжаа олгох сургалтын модуль Боловсролын хүрээлэн боловсруулан 2 удаагийн сургалтаар 100 багшийг хамрууллаа.			
12	29	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 2016-04-14 Дугаар 16-04	15.4.. Төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын тодорхой хувийг эцэг, эх, асран хамгаалагчаас, Нийгмийн халамжийн тухай хуулийн 20.2-т заасан хүүхдийн хоолны зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.	Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын дагуу хүүхдийн хоолны зардлын тодорхой хувийг эцэг эхээс санхүүжүүлэх тухай заалтын дагуу 2017 оны 11 дүгээр сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн боловч 2024 он хүртэл хойшлуулсан. Хүүхдийн хоолны мөнгийг 2020 оны 01 дүгээр сараас эхлэн 50 хувиар нэмэгдүүлж /ердийн цэцэрлэгийн нэг хүүхдэд оногдох хоолны мөнгө 2475 төг, 24 цагийн бүлэгт сурч буй нэг хүүхдэд оногдох мөнгө 3600/ болсонтой холбогдуулан Засгийн газрын 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар тус асуудлыг хэлэлцүүлж цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын нормативыг шинэчлэн тогтоолоо.	70%	70%	
	30		“7.1.. Хүүхдийн чадвар,	Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн	70%	70%	

			чадамж, хөгжлийн ахицыг үнэлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”	болон сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний журмын төсөл боловсруулан хэлэлцүүлэх, турших ажлыг төлөвлөгөөний дагуу хийж байна. Журмын төслийг боловсруулахад дараах чиглэлээр судалгаа хийж судалгааны дүнд тулгуурлан төслийг боловсруулсан. Үүнд: • Хүүхдийн хөгжлийг үнэлж дүгнэж буй өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал бэрхшээл, цаашид сайжруулах хэрэгцээ • Хүүхдийн хөгжлийг үнэлж дүгнэж буй олон улсын туршлага • Сургуульд элсэх насны хүүхдийн хөгжлийн онцлог, сургуульд бэлтгэгдсэн байдлын шалгуурт тавигдах шаардлага • Цэцэрлэгийн үйл ажиллагааны үнэлгээтэй холбогдох шаардлага зэргийг судалж журмыг шинэчлэх чиглэлийг тогтож, төслийг боловсруулж байна. Хүүхдийн хөгжлийг үнэлэх журам, сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх шалгуурыг хэлэлцүүлж, 2020 оны эхний хагас жилд батлуулахаар төлөвлөж байна.			
13	31	Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-05-12 Дугаар 2017.05.12	8.4.2.. 8.4.Хог хаягдлын талаар боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.4.2. Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын сургалтын хөтөлбөрт хог хаягдлын талаархи боловсролын агуулгыг тусгах;	Сургуулийн өмнөх боловсрол: Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2018 оны “Сургалтын хөтөлбөр батлах тухай” А/181 дүгээр тушаалаар “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр"-т хог хаягдлын талаарх агуулгыг тусган хэрэгжүүлж байна. Үүнд: Хог хаяхгүй байх, хог хаягдлаа зориулалтын саванд ялгаж хийж хэвших; Гол, усанд хог хийхгүй байхыг мэдэх; Цаас, усыг гамтай хэрэглэж хэвших. Бага, дунд боловсрол: Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/220 дугаар тушаалаар баталсан дунд ангийн хими, газар зүй, дизайн технологийн сургалтын хөтөлбөрт дараах байдлаар тусгагдсан. Химийн сургалтын	100%	100%	

				<p>хөтөлбөрт: • Бохирдол. Бохирдол ухагдахууныг томьёолж, ус ахуйн хог хаягдлаар бохирдох шалтгааныг олж тайлбарлах, ахуйн нөхцөлд бохирдлоос сэргийлэх, түүнд оруулах хувь нэмрээ тодорхойлж чаддаг болно. Газар зүйн сургалтын хөтөлбөрт: • Байгаль хамгаалал. Байгаль хамгаалах уламжлалт зан үйл, тусгай хамгаалалттай газар нутгийн талаар мэдээлэл цуглуулан боловсруулж, тархалтыг зурагт тэмдэглэн ач холбогдлыг дүгнэж, орон нутагтаа тулгарч буй байгаль орчны тулгамдсан асуудал хог хаягдлыг хэрхэн шийдвэрлэх талаар саналаа боловсруулах, Дизайн технологийн сургалтын хөтөлбөрт: • Хэрэглээнээс гарсан хог хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой баримт мэдээллийг судлах, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар хаягдал материалыг ашиглан хэрэгцээт зүйл бүтээх • Технологи ажилбарын үед гарсан хог хаягдлыг ангилах дахин ашиглах боломжтойг ялгах, ажлын байрны эмх цэгц, аюулгүй байдлыг ханган ажиллах гэх мэт. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/277 дугаар тушаалаар баталсан ахлах ангийн химийн сургалтын хөтөлбөрт дараах байдлаар тусгагдсан. • Халдварт өвчний тархалтыг зохицуулахад хоол хүнсний ариутгал, хувийн ариун цэвэр, бохир ус болон хог хаягдлын цэвэрлэгээ ямар ач холбогдолтойг хэлэлцэх.</p>			
14	32	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай 2017-05-18 Дугаар	8.2.. "Энэ хуулийн 8.1.1-д заасан хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Дунд, ахлах ангийн сургалтын цөм хөтөлбөрүүд бүхэлдээ суралцагчдыг хөгжүүлэх зорилготой. Тэдгээрийн дотроос дараах сургалтын хөтөлбөрүүдээр суралцагчдад амьдрах ухааны болон ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдлэг чадварыг эзэмшүүлж байна. Үүнд: 1.	100%	100%	

		2017.05.18	/8.1.1-д ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгах/”	<p>Дунд ангийн хувьд: Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/302 дугаар тушаалаар баталсан “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа”, “Иргэний боловсрол”-ын сургалтын хөтөлбөрөөр амьдрах ухааны чадваруудыг болон ажил мэргэжлийг танин мэдэх, ажил мэргэжлээ зөв сонгох мэдлэг, чадвар эзэмшүүлж байна. Үүнд: а. 8-9 дүгээр ангид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын модуль, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох гарын авлага, “Суралцах төлөвлөгөө” боловсруулан IX ангид тус бүр 45,500 ширхэг, VIII ангид тус бүр 43,000 хувь хэвлэж, ерөнхий боловсролын нийт сургуульд түгээн хэрэгжүүлж эхэллээ. 8, 9 дүгээр ангийн суралцагчдын мэргэжил сонголтын талаарх судалгаа нэгтгэн дүгнэлээ. Мөн судалгааны үр дүнд тулгуурлан сонгон суралцах хичээлийн орчин бүрдүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх шаардлагатай сургуулиудын жагсаалт гаргалаа.</p> <p>2. Ахлах ангийн хувьд: Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/275 дугаар тушаалаар баталсан бизнес судлал, технологи, урлаг, спорт, эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт суралцагчдад амьдрах чадварууд эзэмшүүлж байна. Мөн ажил мэргэжлийн талаарх мэдлэг чадвар олгож байна.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Нийтлэг шаардлага батлах тухай” 2014 оны А/174 дүгээр тушаалын Ерөнхий суурийн хичээлийн чиглэлийн “Биеийн тамир, эрүүл ахуйн” хэсэгт “Бие бялдраа хөгжүүлэх, эрүүл амьдрах ухаанд суралцах, эрсдэл гамшгийн үед аюулгүй байдлаа хангах, анхан шатны тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлэх” гэж, “Иргэний боловсрол”-ын хэсэгт “Монголын түүх, соёл, улс төр, эдийн</p>			
--	--	------------	--	---	--	--	--

				засаг, эрх зүй, хүний үндсэн эрх, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, багаар ажиллах ур чадварыг хөгжүүлэх” гэж тус тус заасны дагуу их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрт агуулгыг оруулан мөрдөж байгаа нь хуульд нийцэж байна.			
УИХ-ын тогтоол							
15	33	Төрөөс соёлын талаар баримтлах бодлого тухай 2012-05-22 Дугаар 2012 №52	2.1. "Төрөөс соёлын талаар баримтлах бодлого" батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай: Төрөөс соёлын талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардлагатай хууль тогтоомжийн төслийг боловсруулах;	Соёлын тухай хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд хамтран баталсан. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг төслийг боловсруулж БСШУС-ын сайдын 2019 оны 06 дугаар сарын 07-ны 1а/5215 албан бичгээр яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 9-ний хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, 2019 оны 8 дугаар сарын 16-ны өдөр УИХ-д өргөн барилаа. “Кино урлагийг дэмжих тухай” хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан. Мөн Хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 04 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж Номын сангийн тухай болон Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан УИХ-д өргөн мэдүүлсэн. Музейн тухай хуулийн үзэл баримтлалыг 2019 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд хамтран баталсан. Батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төслийг	100%	70%	

				боловсруулж байна.			
	34		2.2. "Төрөөс соёлын талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх.	Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар Соёл, урлагийн салбарт нийт 103.7 тэрбум төгрөг, үүнээс 21.4 тэрбум төгрөг нь урсгал төсөв, 82.2 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын төсөвт батлагдсан нь Дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ий 0.3%, улсын төсвийн орлогын 1.1%-ийг эзэлж байна. Урсгал төсвийн 17.4 тэрбум төгрөгийн улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардалд, 2.1 тэрбум төгрөг нь Засгийн газрын тогтоол шийдвэрийн дагуу жил бүр зохион байгуулагддаг соёл урлагийн арга хэмжээний зардалд, 2.0 тэрбум төгрөг нь соёл урлаг хөгжүүлэх сангийн зориулалтаар зарцуулагдахаар батлагдсан. Соёл урлагийн байгууллагуудын 2018 оны төсвийн 5 хувь буюу 3.1 тэрбум төгрөгийг улсын чанартай болон орон нутгийн соёл урлагийн байгууллагуудын орлого бүрдүүлж байсныг 2019 онд улсын төсвөөс 100 хувь санхүүжүүлж байна. Соёл, урлагийг дэмжих санд 2019 онд батлагдсан 2 тэрбум төгрөг нь Төрөөс баримтлах бодлого болон бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээрх төслийг санхүүжүүлэхэд зарцуулагдана.	70%	70%	
16	35	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт	1.2.. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсролын үйлчилгээг тусгай сургууль болон сэргээн засалтын бусад төрөлжсөн байгууллага эзэмшүүлэх ажлыг шинэчлэн зохион байгуулах;	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/309, А/699, А/460 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрийн	100%	100%	

		оруулах тухай хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2013-02-08 Дугаар 2013.02.08 №19		маягт”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэлийн маягт”-ыг баталсан. Энэ баримт бичиг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх бүхий л үйлчилгээг хэрхэн гүйцэтгэх зохион байгуулалтыг тодорхойлсон баримт бичиг юм. 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг энэ зааврын дагуу хэрэгжүүлж байна. 2018-2019 онд тусгай сургуульд 1740 суралцагч суралцан боловсролын болон сэргээн засах үйлчилгээ авч байна.			
	36		1.3.. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах чиглэлээр мэргэших дохионы хэлний багш, арга зүйч, эмч, согог зүйч зэргийг бэлтгэх зорилгоор нийт 20-оос доошгүй хүнийг жил бүр гэрээгээр, сургалтын төрийн сангийн зардлаар гадаадад сургах арга хэмжээ авах.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах чиглэлээр мэргэших дохионы хэлний багш, арга зүйч, эмч, согог зүйч зэргийг бэлтгэх зорилгоор 2018 оны 11 сараас ОХУ-ын Эрхүү хотын Багшийн сургуультай хамтын гэрээ байгуулж 10 хүнийг, Польш болон Унгарт 10 гаруй багш нарыг төрийн сангийн зардлаар сургаж гадаадад 20 гаруй хүнийг сургасан байна. Цаашид жил бүр Засгийн газар хоорондын гэрээгээр гадаадад суралцах оюутны квотод оруулна.	100%	100%	
17	37	Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2015-12-03 Дугаар 108-2015-12-30	1.1. 1/Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлж хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтаас хасагдсан, хавсралтад заасан төсөл, арга хэмжээнээс нэг маягийн зураг төслөөр барьж болох, 320 хүртэлх суудалтай сургууль, цэцэрлэг, дотуур байрын барилгыг 2016 оны 1	Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан 2016 онд хэрэгжүүлэх ажлыг даалгасан тогтоол байсан. Улсын Их Хурлаар Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 09 -ны өдөр баталсан. 2016 онд шинээр батлагдсан 5 төсөл, арга хэмжээнүүд нь тухайлсан зурагтай байсан бөгөөд бүгд хэрэгжиж дууссан.	100%	100%	

			дүгээр улиралд багтаан концессоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төсөвт тусган ажиллах;				
18	38	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2016-11-03 Дугаар 2016 №51	2.. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авлигатай тэмцэх газар /Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай.	Улсын Их хурлын 2016 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 51 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны Төлөвлөгөө батлах тухай 114 дүгээр тогтоол, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Хөтөлбөр, төлөвлөгөө, зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга, хэмжээний тухай” А/373 дугаар тушаал, Аймгийн боловсрол, соёлын газрын дарга нарт, Нийслэлийн боловсролын газрын дарга, Нийслэлийн соёл, урлагийн газарт тус тус 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 1а/5297, 1а/5298, 1а/5299 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг хүргүүлэн чиглэл, үүргийн дагуу авсан арга хэмжээний мэдээллийг 2019 оны 10 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг даалгасан байгаа болно. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 2019 оныг “Иргэний ёс зүйн боловсролын жил” болгон зарлаж Авлигатай тэмцэх газартай хамтран “УРИАЛГА” гарган хамтран ажиллаж байна. Мөн Авлигатай тэмцэх газрын 2019 оны 03/3631, 01/4296 дугаар албан бичгээр ирүүлсэн Зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор тус яамны газрын дарга нар, Аймаг, Нийслэлийн боловсролын газар, Нийслэлийн дүүргийн боловсролын хэлтсийн дарга, бүх шатны	100%	100%	

				боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч нарт “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичиг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаал батлан хугацаатай үүрэг даалгаврыг тус тус хүргүүлээд байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа нар хамтран ажиллах тухай “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г /хугацаатай 21 хэрэгжүүлэх ажил бүхий/ хамтран батлан, хэрэгжүүлж байна.			
19	39	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017-06-09 Дугаар 2017 №46	1.3.. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, холбогдох байгууллага, албан тушаалтныг оролцуулан сургууль, цэцэрлэгийн хамран сургах тойрогт байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог нарийвчлан гаргаж, тэгш хамруулан сургах орчныг бүрдүүлэн ажиллах;	Боловсролын мэдээлэл удирдлагын системд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг 6 бэрхшээлийн төрлөөр бүртгэж байна. Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй 1,076 хүүхэд цэцэрлэгт, 6,053 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд тус тус суралцаж байна. 2-5 насны хөгжлийн бэрхшээлтэй 1,585 хүүхэд байгаа бөгөөд бүх хүүхдийн 67,8%, 6-18 насны хөгжлийн бэрхшээлтэй 8,209 хүүхдээс 6,053 буюу 73,7% ерөнхий боловсролын сургуульд хамрагдсан байна. Үүнээс 1,700 хүүхэд нь тусгай ЕБС-д сурч байна.	100%	100%	
	40		1.4.. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төвөөр дамжуулан хэвтрийн, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бичиг	ЯХИС-гийн “Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийн хүрээнд “Сургуулийн гадна буй сургуулийн насны хүүхдийг илрүүлэх судалгаа”-г төсөл хэрэгжиж буй 2 аймаг /Ховд, Өвөрхангай/, 3 дүүрэг /Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан/-ийн 18 баг, 20 хороонд хийв.	100%	100%	

		<p>үсгийн болон бага, суурь боловсрол эзэмшүүлэх ажлыг 2017-2018 оны хичээлийн жилээс эхлүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, тохирох хэрэглэгдэхүүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байгаа орчинд суурилуулах, зайн сургалтын тоног төхөөрөмж худалдан авах зардал, багшийн цалинг тооцож улсын төсөвт тусгах;</p>	<p>Судалгааны үр дүнд сургуулийн гадна буй сургуулийн насны нийт 340 хүүхэд илрүүлснээс 121 нь сургууль завсардсан, 219 нь сургуульд огт ороогүй байна. Нийт илэрсэн хүүхдүүдийн 217 нь хөгжлийн бэрхшээлтэй байна. Судалгаагаар илэрсэн сургуулийн гадна байгаа хөгжлийн бэрхшээлтэй 217 хүүхдээс 2019-2020 оны хичээлийн жилд аймаг, дүүргийн НТБТ-ийн бичиг үсгийн болон дүйцсэн хөтөлбөрийн сургалтад 21.5% нь хамрагдсан үр дүнтэй байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр "Тэгш хамруулан сургах боловсрол-Насан туршдаа суралцахуй" нөлөөллийн уулзалтыг 09-11 дүгээр саруудад 8 аймгийн ЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга нар, Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол хариуцсан мэргэжилтэн, ЗДТГ-ын харьяа агентлагуудын дарга, мэргэжилтэн, аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, багийн дарга нар нийт 181 хүнд зохион байгуулав.</p>			
41		<p>1.5.. Бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сургалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, тухайн орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сувилалд тэгш хамруулах асуудлыг тусгаж, үүрэгжүүлж</p>	<p>БСШУС-ын сайдын А/292 тоот тушаалаар батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам"-ын хэрэгжилтийг ханган 21 аймаг, 9 дүүрэгт "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл"-ийг аймаг, дүүргийн БСУГ-ын тушаалаар байгууллаа. Мөн журмын дагуу сургууль дээр "Дэмжих баг" байгуулагдан хүүхдийн сурах орчин, тохирох хэрэглэгдэхүүн, багшийн арга зүйн асуудал дээр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Бүх шатны засаг дарга нарын үр дүнгийн гэрээнд тусгагдсан 2019 оны</p>	100%	100%	

		ажиллах;	ажлын биелэлтийг дүгнэж байна.			
42		1.6.. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэн оношлоход шаардагдах оношилгооны иж бүрэн тоног төхөөрөмж, тусгай хэрэгцээт сургуулийн зориулалтын тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын хүртээмжтэй материал, хэрэгсэл, сурагчдыг тээвэрлэх автобусаар хангах;	2018-2019 оны хичээлийн жилд Бага дунд боловсролын хуулийн 13.4 дэх хэсэгт "Ерөнхий боловсролын тусгай сургууль нь ерөнхий боловсролын бусад сургууль, багш, иргэн, гэр бүл, олон нийтэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ" гэж заасны дагуу ерөнхий боловсролын 55 дугаар сургууль нийслэлийн 25 сургуулийн захирлуудад сургалтын орчин, тохирох хэрэглэгдэхүүнийг сонгох, хүүхэдтэй ажиллах арга зүйн 1 өдрийн сургалт зохион байгууллаа. Мөн дүүргийн боловсролын хэлтсийн дарга, мэргэжилтэн 65 хүнийг хамруулж "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах журам"-ын хэрэгжилтийг хангах талаар өдөрлөг зохион байгуулсан. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр насан туршийн боловсролын багш нарын тэгш хамруулах болон тусгай боловсролын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлэгт зохион байгуулах арга зүйг сайжруулах зорилготойгоор "Тэгш хамруулан сургах боловсрол" сургалтыг үндэсний хэмжээнд 8 бүсэд 2019 оны 09 дүгээр сард зохион байгуулж, нийт 453 багшийг хамрууллаа.	100%	100%	
43		1.7.. Тусгай сургуульд ажиллаж байгаа багш, ажилтан, албан хаагчдын цалингийн нэмэгдлийг шинэчлэн тогтоох, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хөгжлийн	Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид үндсэн цалингийн 10 хувийг олгохоор тогтоолын төсөл боловсруулан БСШУС-ын сайдын 2019 оны 8 дугаар сарын 27-ны 1а/7613 тоот албан бичгээр ХНХЯ-нд хүргүүллээ.	100%	100%	

		бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамааран хувьсах зардлыг нэмэгдүүлэх болон ажилласан жил, ур чадвар, ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулсан багш, ажилтан, албан хаагчдын цалин урамшууллын шинэ тогтолцоог бий болгох, зардлыг холбогдох төсөвт жил бүр тусгах;				
44		1.8.. Тусгай хэрэгцээт боловсролын байгууллагын багшлах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгах;	Мөн тус сургууль нь цэцэрлэгчийн анги нээн ажиллуулж 10 сурагч суралцаж байна. Дэлхийн банкны санхүүжилтээр Ерөнхий боловсролын 63 дугаар сургууль мужааны мэргэжил, ур чадвар олгох цех байгуулан хүүхдүүдийг сургаж, бүтээгдэхүүн гаргаж эхлээд байна.	100%	0%	Бодитой, хамаарал бүхий асуудлыг тайлагнахад анхаарах.
45		1.14.. Тусгай хэрэгцээт боловсролын байгууллагад хүүхдийн тооноос хамааран туслах багш ажиллуулах, цалин, урамшууллыг жил бүрийн төсөвт тусгах.	"Туслах багш" гэсэн албан тушаалыг Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар цалингийн сүлжээнд шинээр оруулсан. Одоо ажиллаж байгаа болон шинээр туслах багшаар ажиллах багш нарын цалинг 2020 оны улсын төсөвд тусгах ажлыг зохион байгуулахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосон. "Багшийн хөгжлийг дэмжих хууль"-ийн 8.4 дэх хэсэгт "Ерөнхий боловсролын сургуулийн 44-өөс дээш хүүхэдтэй нэг, хоёрдугаар анги нь туслах багштай байж болно"	100%	100%	

				гэж заасан. Тиймээс ердийн ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслах багшийн үйлчилгээ үзүүлэх боломжтой. Одоо ажиллаж байгаа тусгай сургууль, цэцэрлэгүүдэд 95 туслах багш ажиллаж байна. Дээд боловсролд туслах багш ажиллуулах шаардлагагүй. Сургалтын орчин, сургалтын материал, тоног төхөөрөмжөөр ханган элсэлтийн журамд өөрчлөлт орууллаа. 2019 оны 6 сарын байдлаар 6247 хөгжлийн бэрхшээлтэй оюутан суралцаж 8,171.465,479 төгрөг буцалтгүй тусламжаар олгосон байна.			
20	46	Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2017-11-14 Дугаар 2017 №69	1.. 1/Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуульд бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад “сахилга, хариуцлага, ажлын үр дүнг урамшуулах” зориулалтаар батлагдсан хөрөнгийг зарцуулахтай холбогдуулан төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, үйл ажиллагааны үр дүн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэх, ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнд үндэслэн урамшуулах тогтолцоог бий болгох, энэ талаар холбогдох журам баталж мөрдүүлэх;	Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3, 40.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, 52 дугаар зүйлийн 52.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1, 4.7 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/796 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийг дүгнэлтийг тус тус үндэслэн дараах ажлыг зохион байгуулж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан , спортын төсвийн ерөнхийлөн захирагч, БСШУС-ын сайд тус яамны харьяа 100 байгууллагын төсвийн шууд захирагчтай Төсвийн тухай хуулийн дагуу 2019 оны Үр дүнгийн гэрээг байгуулж, Төрийн албаны тухай хуулийн дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангуулж ажиллалаа. Ерөнхий боловсролын лаборатори, тусгай сургууль тусгай цэцэрлэгийн захирлын ажлын үр дүнг 2019 оны улирал тутамд үнэлж дүгнэн, зохих урамшууллыг олгож ажиллав. 2019 оны хагас жилээр төсөв санхүүгийн хууль	70%	70%	

				тогтоомж зөрчиж, ноцтой алдаа гаргасан 28 дугаар сургуулийн захирал Ц.Манахүүд хариуцлага тооцов. БСШУССайдын 2019 оны А/796 дугаар тушаалаар төсвийн шууд захирагчдын 2019 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлэх, дүгнэх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, үр дүнгийн үнэлгээг албажуулах шатандаа байна.			
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
21	47	Сургалтын төрийн сангийн зээлийн ашиглалт, төлөлт, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай 2013-04-16 Дугаар 2013 №04/04 НББСШУБХ/ТБХ	1.9/. олон улсын нэр хүндтэй сургуулиудад Засгийн газраас тодорхойлсон эрэлттэй мэргэжил болон хөдөлмөрийн зах зээлд чухал шаардлагатай байгаа өндөр технологийн болон инженер, нийгмийн чиглэлийн мэргэжлээр суралцах оюутны тоог нэмэгдүүлэх,	Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-ыг баталж дэлхийн 10 гаруй улсад 267 оюутан суралцаад байна. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу тухайн орны Элчин сайдын яамдтай хамтран сонгон шалгаруулалтыг ил тод, хөнгөн шуурхай, боловсронгуй болгох зорилгоор доорх арга хэмжээг авч хэрэгжүүлээ. - Бүртгэлийг 100 хувь онлайн хувилбарт шилжүүлж, - Бүртгэлийн давхардлыг арилгах зорилгоор БНХАУ, ОХУ, Унгар, Солонгос, Вьетнам, Польш, Турк зэрэг 16 орны элчин сайдын яамтай хамтран, хяналт тавьж ажиллаж байна. Боловсролын удирдлагын мэдээллийн системээр дамжуулан гадаадад сурах оюутныг бүртгэдэг мэдээллийн системийн тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна.	100%	100%	
22	48	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2015-06-13 Дугаар 2015_11	2. Боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3, 39 дүгээр зүйлийн 39.12, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 7	2019 онд "Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн хэрэглэгдэхүүн" 2019 он, "Суралцахуйн хоцрогдолтой, зан үйлийн эмэхтгэл хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүй, хэрэглэгдэхүүн" 2019	100%	100%	

		<p>дугаар зүйлийн 7.1, 7.2, 8 дугаар зүйлийн 8.6, Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, 7.10 дахь хэсэгт заасан журам, үлгэрчилсэн дүрэм, стандартыг боловсруулж, батлан мөрдөх</p>	<p>он, “Дохионы хэлээр харилцаж сурцгаая” Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан багц карт 2019 он, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үгийн нөөц нэмэгдүүлэх хэл ярианы дутмагшилтай хүүхдэд зориулсан “Зурган таних тэмдгийн эмхэтгэл” -ийг 144.886.000 төгрөгөөр 29.700 ширхэг хэвлэн улс бүх сургууль, насан туршийн боловсролын төвүүдэд хүргүүллээ. Мөн шинээр “Айзамт хөдөлгөөнт дасгал” хичээлийн багшийн ном, “Яриа бичиг” хичээлийн багшийн ном, “Биет зүйл” хичээлийн багшийн номыг боловсруулан гаргасан.</p>			
49		<p>б. Үндэсний уламжлалаа хадгалсан ёс суртахуунтай хүүхэд, залуучуудыг төлөвшүүлэх чиглэлээр суурь боловсрол олгох сургалтын хөтөлбөрт Монгол Улсын түүх, өв соёл, эх хэл, ёс заншлын агуулгыг нэмэгдүүлэх, түүнд үнэлгээ хийх, шалгуур тогтоох эрх зүйн орчныг боловсронгуй блогдох</p>	<p>Нэг. “Иргэний ёс зүйн боловсролын жил”-д ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын судлах “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэллээ. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 2019 оны А/491 дүгээр тушаалаар бага, дунд, ахлах ангийн сурагчид “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийг долоо хоногт тус бүр 2 цагаар судлахаар баталсан. “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийн зорилго нь хүнлэг энэрэнгүй, билиг оюун төгөлдөр, монгол үндэстнийхээ хэл, соёлыг эзэмшсэн, бахархаж хэрэглэдэг, хүндэлж хамгаалдаг, эх орноо эрхэмлэн дээдлэх үүрэг, хариуцлагаа ухамсарласан монгол иргэнийг өсгөх, хүмүүжүүлэх, бэлтгэхэд чиглэж байна. Хоёр. 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 200 дугаар тогтоолоор “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлууллаа. Үндэсний хөтөлбөрийн зорилго нь хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, эх орноороо болон монгол хүн</p>	100%	100%	

				болж төрснөөрөө бахархах, улс орныхоо тусгаар тогтнолын баталгааг нэмэгдүүлж, түүх, байгалийн унаган төрхийг хадгалж, экосистемийн тэнцвэрт байдал болон тогтвортой хөгжлийг хангахад оршино.			
	50		7. Зах зээлд худалдаалагдах хүүхдийн үлгэрийн, уран зохиолын болон бусад төрлийн номын агуулга, зураг, текстэд тавигдах шаардлага, стандартыг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавих механизмыг бүрдүүлэх	Зах зээлд худалдаалагдах хүүхдийн үлгэрийн, уран зохиолын болон бусад төрлийн номыг худалдан авч ерөнхий боловсролын сургуулийн номын санд баяжилт хийхдээ дараах зарчим баримталж байна. 1. Хэвлэлийн компаниудаас нийлүүлэх номын жагсаалтыг номын хамт авч байна. 2. Хэвлэлийн компанийн ирүүлсэн номууд сурагчдад тохирох эсэхийг багш нараар хянуулж байна. 3. Шаардлага хангаж буй номуудаар катологи гаргаж сургуульд хүргэн багш нараар сонголт хийлгэн худалдан авч байна. Мөн "Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага MNS 5418:2008 стандартыг мөрдөж байна.	30%	30%	
23	51	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016-03-26 Дугаар 2016 №09/03 НББСШУБХ/ТБХ	1.2/. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг амьдралд бэлтгэх, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусган ажиллах, сургалтын хөтөлбөрийг дараагийн шатны сургалтын байгууллагын агуулгад шилжихэд дөхөмтэй байхаар шинэчлэн боловсруулах, мэргэжлийн сургалтад хамрагдаж зохих ур чадвар эзэмшсэнийг гэрчлэх чадамжийн гэрчилгээ,	2019 оны 9 дүгээр сарын байдлаар ерөнхий боловсролын сургуулийн 521 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч тусгай сургуулийн болон мэргэжлийн сургалтын байгууллагын мэргэжлийн чиг баримжаа олгох богино хугацааны бүлгийн сургалтад хамрагдаж байна. Эдгээр сурагчдад мэргэжлийн сургалтад хамрагдаж зохих ур чадвар эзэмшсэнийг гэрчлэх чадамжийн гэрчилгээ олгоно.	100%	100%	

		сертификат, мэргэжлийн үнэмлэх олгох				
52		1.3/. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, холбогдох байгууллага, албан тушаалтан хамтран сургууль, цэцэрлэгийн хамран сургах тойрогт байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог нарийвчлан гаргаж, тэгш хамруулан сургах орчныг бүрдүүлэн ажиллах талаар санаачилга гаргах, энэ чиглэлийн үйл ажиллагааны үзүүлэлтийг хамтран ажиллах үр дүнгийн гэрээ, тэргүүний сургууль, цэцэрлэг шалгаруулах үзүүлэлтийн нэг болгон оруулах	Монгол Улсын хэмжээнд 2-5 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 1,585 байгаа бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилд цэцэрлэгт 1,076 хүүхэд хамрагдаж байна. Хамран сургалт 67,8 хувьд хүрч, өмнөх оноос 10,6 хувиар нэмэгдсэн. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар “Хүүхэд харах үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” асуудлыг хэлэлцүүлж, 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн төсвийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг харах үйлчилгээний санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчны стандарт, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмжид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч хөгжих орчныг бүрдүүлэх чиглэлээр тусгагдсан бөгөөд энэхүү стандартын хэрэгжилтийн үнэлгээг улсын хэмжээнд хийх бэлтгэл ажлыг хангаад байна. Бүх шатны сургалтын байгууллагад сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тохирох хэрэглэгдэхүүн, сурах орчин бүрдүүлэх журмын төслийг хэлэлцэж байна.	100%	100%	
53		1.4/. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, аймаг, дүүргийн Насан туршийн боловсролын төв, сумын нэгжүүдээр дамжуулан хэвтрийн, хүнд хөгжлийн бэрхшээлтэй	Японы ХИС-гийн “Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийн хүрээнд “Сургуулийн гадна буй сургуулийн насны хүүхдийг илрүүлэх судалгаа”-г төсөл хэрэгжиж буй 2 аймаг /Ховд, Өвөрхангай/, 3 дүүрэг /Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан/-ийн 18 баг, 20 хороонд хийв. Судалгааны үр дүнд сургуулийн гадна буй сургуулийн насны нийт 340 хүүхэд илрүүлснээс	100%	100%	

		<p>хүүхдэд бичиг үсгийн болон бага, суурь боловсрол эзэмшүүлэх ажлыг 2017-2018 оны хичээлийн жилээс эхлүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байгаа орчинд суурилуулах зайн сургалтын тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах, багшийн цалинг тооцож улсын төсөвт тусгах;</p>	<p>121 нь сургууль завсардсан, 219 нь сургуульд огт ороогүй байна. Нийт илэрсэн хүүхдүүдийн 217 нь хөгжлийн бэрхшээлтэй байна. Судалгаагаар илэрсэн сургуулийн гадна байгаа хөгжлийн бэрхшээлтэй 217 хүүхдээс 2019-2020 оны хичээлийн жилд аймаг, дүүргийн НТБТ-ийн бичиг үсгийн болон дүйцсэн хөтөлбөрийн сургалтад 21.5% нь хамрагдсан үр дүнтэй байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр “Тэгш хамруулан сургах боловсрол-Насан туршдаа суралцахуй” нөлөөллийн уулзалтыг 09-11 дүгээр саруудад 8 аймгийн ЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга нар, Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол хариуцсан мэргэжилтэн, ЗДТГ-ын харьяа агентлагуудын дарга, мэргэжилтэн, аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, багийн дарга нар нийт 181 хүнд зохион байгуулав.</p>			
54		<p>1.6/. Тусгай хэрэгцээт боловсролын сургууль, цэцэрлэгийн чиг үүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхдийн хамт сургаж, хөгжүүлж байгаа төрийн болон төрийн бус өмчийн сургалтын байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийг нэмж оруулах,</p>	<p>2018-2019 оны хичээлийн жилд Бага дунд боловсролын хуулийн 13.4 дэх хэсэгт "Ерөнхий боловсролын тусгай сургууль нь ерөнхий боловсролын бусад сургууль, багш, иргэн, гэр бүл, олон нийтэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ" гэж заасны дагуу ерөнхий боловсролын 55 дугаар сургууль нийслэлийн 25 сургуулийн захирлуудад сургалтын орчин, тохирох хэрэглэгдэхүүнийг сонгох, хүүхэдтэй ажиллах арга зүйн 1 өдрийн сургалт зохион байгууллаа. Мөн дүүргийн боловсролын хэлтсийн дарга, мэргэжилтэн 65 хүнийг хамруулж "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах журам"-ын хэрэгжилтийг хангах талаар өдөрлөг зохион байгуулсан. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр</p>	100%	100%	

			насан туршийн боловсролын багш нарын тэгш хамруулах болон тусгай боловсролын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлэгт зохион байгуулах арга зүйг сайжруулах зорилготойгоор “Тэгш хамруулан сургах боловсрол” сургалтыг үндэсний хэмжээнд 8 бүсэд 2019 оны 09 дүгээр сард зохион байгуулж, нийт 453 багшийг хамрууллаа.			
55	1.7/. "Хүүхэд, хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр 2016-2024 он" хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг тусган батлуулж, хэрэгжилтийг хангах	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг батлуулсан. Тус хөтөлбөрийн 3.1.3.4. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийг хүүхдээ асрах, сэргээн засах, хөгжүүлэх чиглэлийн сургалтад үе шаттай хамруулах. 3.2.1.6. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суурь боловсролд тэгш хамруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх; 3.2.1.7. тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэн боловсруулах; 3.3.1.2. эрсдэлт нөхцөлд байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд орон нутгийн болон үндэсний хэмжээнд зохион байгуулагдах хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх зэрэг заалтуудыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	100%		
56	1.8/. Ерөнхий боловсролын тусгай сургуулиуд дэргэдээ сургалт, үйлдвэрлэл,	Мөн тус сургууль нь цэцэрлэгчийн анги нээн ажиллуулж 10 сурагч суралцаж байна. Дэлхийн банкны санхүүжилтээр Ерөнхий боловсролын	100%	100%		

		дадлагын аж ахуйтай байхыг дэмжих	63 дугаар сургууль мужааны мэргэжил, ур чадвар олгох цех байгуулан хүүхдүүдийг сургаж, бүтээгдэхүүн гаргаж эхлээд байна.			
57		1.9/. Их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй оюутны тоог нарийвчлан гаргах мэдээллийн маягттай болох, дээрх сургуулиудын дэргэд хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулсан тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, үйлчилгээ үзүүлэх төвийг бий болгох,	2019-2020 оны хичээлийн жилээс дээд боловсролын удирдлага мэдээллийн нэгдсэн санг шинээр бүрдүүлэхтэй холбогдуулан их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй оюутны тоог нарийвчлан гаргах мэдээллийн маягыг шинээр боловсруулсан. тус маягтад суралцагч өөрөө хөгжлийн бэрхшээлтэй эсвэл эцэг эхийн хэн нэг нь хөгжлийн бэрхшээлтэй буюу харааны, сонсголын, аутизм, бие бялдрын бэрхшээлтэй гэсэн ангиллаар тоог гаргуулж авсан. Дээд боловсролын шинэчлэлийн төслийн санхүүжилттэйгээр тусгай хэрэгцээт боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл нийлүүлэх” тендерийг зохион байгуулах Үнэлгээний хороо 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/240 тоот Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулан Техникийн тодорхойлолтыг МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн багш нартай хамтран боловсруулж сургалтын хэрэглэгдэхүүнийг 79.392 ам.долларт харааны болон сонсголын бэрхшээлийн төхөөрөмж худалдан авахаар төлөвлөн бүх чиглэлийн хөгжлийн бэрхшээл буюу хараа, сонсгол, сэтгэл хөдлөл зан үйл, бие мах бодь, оюун ухаан суралцахуй, хэл ярианы гэсэн бүх чиглэлээр хэрэглэгдэхүүн худалдан авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн Оюутан хөгжлийн төвийг МУБИС-ийн дэргэд байгуулсан ба хөгжлийн бэрхшээлтэй оюутанд үйлчлэх	100%	100%	

			туслах ажилтан ажиллуулсан. Мөн АШУҮИС-ийн Сувилахуйн сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй оюутанд суралцах нөхцөлийг сайжруулах зорилгоор дохионы хэлний мэргэжлийн багшийг хөлслөн авч хамтран ажилласан.			
58		2.14/. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд саадгүй зорчих зам, орц, гарцыг Ерөнхий боловсролын тусгай сургууль, цэцэрлэгийн орчинд бий болгож, таних тэмдэг байршуулж, гадны автомашин зогсохгүй байхаар журамлах,	Сургуулийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS2019:6782” стандарт, дотуур байранд амьдарч буй сурагчдын сурч хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлж, хүүхдийн эрхийг дээдэлсэн, тэдний сэтгэл хангалуун, амжилттай сурч хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор “ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS2019:6781” стандартыг Стандартчилал хэмжил зүйн газрын даргын 2019 оны 40 дүгээр тушаалаар тус тус батлуулаад байна.Энэ стандартад Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын байгууллагын гадаад, дотоод орчны хэм хэмжээг зааж оруулсан.	100%	100%	
59		1.15/. Шинээр барих шаардлагатай Баянзүрх дүүргийн сувиллын цэцэрлэг яслийн 10 дугаар цогцолборын барилга, Сүхбаатар дүүргийн 25 дугаар тусгай сургуулийн өргөтгөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар тусгай сургуулийн	Баянзүрх дүүргийн сувиллын цэцэрлэг яслийн 10 дугаар цогцолборын барилгын гүйцэтгэгчээр Алтанбулаг трейд ХХ шалгарч ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 12 сард багтаан улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Сүхбаатар дүүргийн 25 дугаар тусгай сургуулийн өргөтгөлийн барилга, 116 дугаар тусгай сургуулийн дотуур байрны барилга барих санхүүжилтийг 2020 оны төсвийн төсөлд тусган 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад	100%	100%	

		дотуур байрны барилга, байгууламжийг Улсын төсвийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн жагсаалтад оруулж, Монгол Улсын 2016 оны төсвийн тодотголын төсөлд тусгаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	хүргүүлсэн боловч, УИХ-аар санал дэмжигдэхгүй хасагдсан.			
60		1.16/. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг бие даан нийгмийн харилцаанд оролцоход бэлтгэх, мэдлэг чадвар мэргэжлийн чиг баримжаа олгох нөхөн сэргээх сургалт, үйлдвэрлэл хөгжлийн төвийг шинээр байгуулахад шаардагдах санхүүжилтийг үе шаттай шийдвэрлэх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын ордны барилгын төсвийг 2018 оны 4 дүгээр сард "2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл"-д тусгаж Сангийн яаманд хүргүүлсэн. 2018 оны 6 дугаар сард "2019 оны төсвийн хязгаар"-т саналыг тусгаж Сангийн яаманд хүргүүлсэн. 2019 оны төсөвт тус ордны барилгын төсөв батлагдаагүй. БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдах Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын ордны барилгын ажил эхлүүлэх Хятадын талын судалгааны баг ирж, барилгын ажлыг гүйцэтгэхэд холбоотой төрийн байгууллагуудтай зохих уулзалт хийн гэрээ байгуулахаар төлөвлөж байна. Монголын талын хариуцах ажил, ашиглалтын өмнөх захиргаа байгуулах, үйл ажиллагааны төсөв Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцад /4.0 тэрбум төгрөг/ батлагдсан. Тус ажлын бэлтгэл хангах ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам удирдан зохион байгуулж байна.	30%	30%	
61		2.. Тогтоолын биелэлтийг 2016 оны хаврын чуулганы хугацаанд багтаан Нийгмийн	Байнгын хороонд танилцуулагдсан.	100%	100%	Танилцуулсан огноо, гарсан шийдвэрийг

			бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Төсвийн байнгын хорооны хуралдаанд тус тус танилцуулахыг Монгол Улсын Засгийн /Ч.Сайханбилэг/, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам /Л.Гантөмөр/, Сангийн яам /Б.Болор/, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам /С.Эрдэнэ/, Эрүүлмэнд, спортын яам /Ч.Оюунбаатар/-нд тус тус даалгасугай.				тодорхой тайлагнах. Холбогдох баримт, нотолгоог хавсаргах.
24	62	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ	1.5. жил бүрийн хичээлийн жил эхлэхэд их, дээд сургуулийн оюутан, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг сүрьеэ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг тогтмол зохион байгуулах,	Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны 11 сарын 27-ны А/480, А/739 тоот “Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг зохион байгуулах тухай” тушаалын дагуу жил бүр оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян зохион байгуулан ажиллаж байна. Энэ хичээлийн жилд хүрээнд Эрт илрүүлгийн 6 төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх шинжилгээ/ /Сүрьеэ, БЗДХ, ДОХ, хорт хавдар, халдварт өвчин/ оршин суугаа харьяалал харгалзахгүй хамруулах ажлыг зохион байгуулж нийт шинээр элсэгчдийн 90 гаруй хувь нь хамрагдсанаас 54 гаруй хувь дотуур байранд амьдардаг оюутнууд байна. Мөн дээд боловсролын сургалтын байгууллагууд нь Оюутанд эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, эрүүл мэндийн төв болон эмчтэй байхад анхааран ажиллаж суралцагчдынхаа эрүүл мэндийн даатгалыг	100%	100%	

			<p>төлүүлэх, хөнгөлөх, эрүүл амьдрахад нь зөвлөн ажиллаж байна. Тухайлбал 10 дугаар сарын 8-нд МУИС-ийн дотуур байрны оюутнуудад Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны “САЙН НАРАН” Өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч М.Нармандах “Бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвийн хүрээнд гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс хамгаалах аргууд болон ХДХВ/ДОХ, тэмбүү зэрэг бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар яриа, таниулга хийж оюутнуудын сонирхсон асуултад хариулан зөвлөгөө өгч ажиллаа.</p>			
63		<p>1.7. Сүрьеэ, БЗДХ, ХДХВ/ДОХ-ын болон лабораторийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэх сургалтыг зохион байгуулах, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх, энэ чиглэлээр хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх;</p>	<p>2019 оны 2 дугаар сарын 25-ны БСШУССайд, ЭМСайд нарын хамтарсан А/97 дугаар тушаалын дагуу жил бүрийн 10 дугаар сард оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян зохион байгуулж хэвшээд байна. Энэхүү аяны хүрээнд эрт илрүүлгийн 6 төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх шинжилгээ/ /Сүрьеэ, БЗДХ, ДОХ, хорт хавдар, халдварт өвчин/ оршин суугаа харьяалал харгалзахгүй хамруулах ажлыг зохион байгуулж нийт шинээр элсэгчдийн 90 гаруй хувийг хамруулсан. 2019 оны 10 сард эрүүл мэндийн газартай хамтарсан "Бүх нийтээр сүрьеэ өвчингүй байх аян"-ыг зохион нийт оюутнуудын 80 гаруй хувийг үзлэгт оролцож сургалт, зөвлөгөө аван хяналтад орж үнэ төлбөргүй үйлчлүүллээ. 2019 оны 11 дүгээр сарын 16-нд Эрүүл мэндийн сайдын баталсан удирдамжийн дагуу их дээд сургуулиудын 800 гаруй оюутанд хэлэлцүүлэг сургалт хийлээ. Сургалтад БЗДХ, ДОХ, сүрьеэ, халдварт болон халдварт бус өвчин, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулсан. Их,</p>	100%	100%	

				дээд сургуулийн оюутнуудад эрүүл мэндийн боловсрол олгох, оюутанд хандсан нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, эрүүл мэндийн даатгалд хамрагдахад зөвлөн туслах, анхан шатны тусламж үйлчилгээг их, дээд сургуулийн “Эрүүл мэндийн төв”-өөр дамжуулан хэрэгжүүлж байна.			
25	64	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ	1.6. их сургууль, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалтүйлдвэрлэлийн төвд суралцагсад болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг жил бүр тогтмол зохион байгуулах;	Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяныг Эрүүл мэндийн яам, Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран “Эрүүл оюутан-хөгжлийн түүчээ” уриан дор 2019 оны 10 дугаар сард зохион байгуулж, оюутан залуучуудыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах, зөв дадал суулгахад чиглүүлсэн. Тус аяны хүрээнд их, дээд сургуулийн оюутнуудад эрүүл мэндийн чиглэлээр сургалт явуулж, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эрсдэлийн үнэлгээ, халдварт болон халдварт бус өвчний үзлэг, элэгний ВС вирус илрүүлэх шинжилгээнд хамруулж ажилласан.	100%	100%	
	65		1.7. ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт эрүүл мэндийн хичээлийн цагийг бие даасан хэлбэрээр оруулж, тэдэнд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар насны онцлогт нь тохирсон боловсрол эзэмшүүлэх;	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын болон Эрүүл мэндийн сайдын 2018 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн А/004/А/01 хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд-ын сайдын 2018 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/467 дугаар тушаалаар батлууллаа. Ерөнхий боловсролын сургуулийн 4-12 дугаар ангид хэрэгжүүлэх эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрийн агуулгыг нийгмийн хэрэгцээ; орон	100%	100%	

				<p>нутаг, сургуулийн онцлог; суралцагчдад тулгамдаж буй асуудалд суурилсан хувийн ариун цэвэр, орчны эрүүл ахуй, хооллолт, хөдөлгөөн, сэтгэцийн эрүүл мэнд, хорт зуршил, бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, осол гэмтэл гэсэн агуулгатай боловсруулсан бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилээс ЕБС-ийн 1-12 дугаар ангид уг сургалтын хөтөлбөрийг судалж байна. ЕБС-ийн Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт “Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд”-ийн агуулгын эзлэх хувь хэмжээ, цагийн хувьд авч үзэхэд ЕБС-ийн Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт бага боловсролд эрүүл мэндийн хичээл 80 цаг судалж байгаагаас бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар 15 цаг буюу 18.7%, суурь боловсролын түвшинд 140 цаг эрүүл мэндийн хичээл орж байгаагаас 29 цаг буюу 20.6%, бүрэн дунд боловсролын түвшинд 105 цаг судалж байгаагаас 27 цаг буюу 25.7 %-нь хүүхдийн нас, бие, хөгжлийн онцлогт тохирсон агуулгаар тус тус судалж байна. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр суралцагчдад насан туршийн эрүүл амьдралын хэв маягийн талаарх хувь хүний хариуцлагыг ухамсарлан, өөрийн болон бусдын, цаашлаад хүрээлэн буй орчныхоо эрүүл, аюулгүй байдлыг хангах, хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм.</p>			
Ерөнхийлөгчийн зарлиг							
26	66	Хадны зураг, бичээсийг хамгаалах, судлах ажлыг	1.. Өвөг дээдсийн хаданд мөнхөлсөн хосгүй гайхамшигт чулуун судар, түүх, соёл, урлагийн нандин	Засгийн газрын 2019 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Чулуун соёлын өв үндэсний хөтөлбөр”-т хадны зургийн бүртгэн баримтжуулах, судлах, сэргээн засварлах,	100%	100%	

		<p>дэмжих тухай 2017-07-09 Дугаар 2017_181</p>	<p>өв: хадны зураг, бичээсийг хадгалан хамгаалах, судлан шинжлэх талаар эрдэмтэн судлаачид, иргэд, байгууллагаас гаргаж буй санал, санаачилгыг дэмжих ЗОРИЛГООР, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь: 1.Хил дамнасан соёлын өв, түүний дотор хадны зураг, бичээсийг судлах зорилгоор олон улсын хамтарсан судалгааны баг байгуулж ажиллах; Хадны зураг, бичээсийн олон улсын эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн-“Хадны зураг, бичээсийн чуулган”-ыг хоёр жил тутамд нэг удаа Дэлхийн өвийн өдрийг тохиолдуулан зохион байгуулж байхыг Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шинжлэх Ухааны Академид даалгасугай.</p>	<p>хамгаалах, сурталчлах чиглэлээр 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн зарим ажлуудыг эхлүүлээд байна. Тухайлбал, Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уулын хадны зураг, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Жаргалантын ширээний хадны зургийн хэв хуулбар, дардсыг авч хадгалах ажлыг хэрэгжүүлээд байна. Монгол-Оросын хамтарсан "Хадну зургийг судлах анги" Баян-Өлгий аймгийн Улаанхус, Буянт сумдын нутагт ажиллаж, Цагаан салаа, Бага Ойгор, Хөлцөөтийн хадны зургаас хуучин чулуун зэвсгийн үед холбогдох хадны зургийг дагнан судалж байна. Мөн ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн шинжилгээний анги Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн нутагт орших хадны зургийг бүртгэн баримтжуулах суурь судалгааны ажлыг хэрэгжүүлж байна.</p>			
--	--	--	---	--	--	--	--

27	67	<p>Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46</p>	<p>1.. Монгол бичгийн цахим кодыг хэрэглэх үндэсний стандартыг холбогдох мэргэжилтнүүдийн саналыг тусган шуурхай боловсруулж, хуульд заасны дагуу батлуулах, цаашид хөгжүүлэн тогтвортой байдлыг хангаж, цахим орчинд үнэдсний хэрэглээг нэмэгдүүлэх талаар бодлого, төлөвлөгөө гарган ажиллахыг Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Монгол хэлний тухай хуулиар үүрэг хүлээсэн эрх бүхий судалгааны байгууллагад; Үндэсний стандартыг боловсруулах ажилд хяналт тавьж, боловсруулсан стандартыг судалж батлах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, монгол бичгийн цахим кодчиллыг олон улсын стандартад үнэдсний стандартыг хэлэлцүүлэх, батлуулах ажлыг зохион байгуулахыг Стандартчилал, тохирлын үнэлгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Монгол Улсын Шадар</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх тухай” 2018 оны 46 дугаар зарлиг, Ерөнхий сайдын 2018 оны 95 дугаар захирамжаар өгсөн чиглэл, үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Олон улсын компьютерын кодчиллын стандартын байгууллага Юникод Консорциумаас 2019 оны 4-р сарын 3-наас 5-ны өдрүүдэд зохион байгуулсан “Монгол бичгийн юникодын ажлын хэсгийн гуравдугаар хурал”-ыг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн хамтран зохион байгуулагчаар оролцлоо. Энэхүү хурлаар - Монгол бичгийн үсэг бүтээх дүрмийг боловсронгуй болгох замаар авиазүйн загварыг хялбаршуулах, боловсронгуй болгох; - Монгол бичгийн цэг, таслал, форматын удирдлагыг авч хэлэлцэх; - Хэрэглэгчид хялбар дөхөм байх, харагдац сайтай, тогтвортой, бүрэн нийцэлтэй монгол бичгийн кодчиллын дүрэм боловсруулах асуудлыг хэлэлцэв. Хурлаас дараах ерөнхий дүгнэлт гарсан болно. Үүнд: Нөхцөл, дагаврыг удирдах таслахгүй нарийн зайг удирдах тэмдэг (NNBSP) талаар: Монгол улс, ӨМӨЗО-ны талууд таслахгүй нарийн зайн удирдах тэмдэг буюу NNBSP-ийн хэрэглээ ихээхэн асуудал дагуулж байгаа талаар байр сууриа илэрхийлж, түүнийг хэрэглэхгүй байх талаар ижил байр суурьтай байлаа. - Эгшиг тусгаарлалтын удирдах тэмдэг MVS талаар: Хуралд оролцогчдын зүгээс MVS удирдах тэмдэгтийн дүрмийг илүү нарийвчлан тодорхойлох шаардлагатай гэсэн байр суурийг дэмжсэн.</p>	100%	100%	
----	----	--	---	--	------	------	--

			сайдад чиглэл болгосугай.				
28	68	Наймдугаар Богд Жавзандамба хутагтын мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэх тухай 2019-01-24 Дугаар 2019_09	2.. а. наймдугаар Богд Жавзандамба хутагтын түүхэн гавьяаг мөнхжүүлсэн дурсгалын цогцолборыг Богд хааны ордон, музейн дэргэд /орчимд/ байгуулах	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Богд хааны ногоон ордны цогцолборын зүүн хойд, зүүн талын газрыг цэцэрлэгжүүлж, Богд хааны дурсгалын цогцолбор байгуулах ажлыг эхлүүлсэн.	70%	70%	
	69		2.. б. наймдугаар Богд Жавзандамба хутагтын түүх, Монголын төлөө явуулсан үйл хэргийн түүхэн болон улс төрийн ач холбогдлын талаар олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Богд хаан 150: Түүх, соёл, өв" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Хуралд Монгол, ОХУ, Япон, Герман, Унгар, Польш, БНХАУ зэрэг орны 30 гаруй эрдэмтэд илтгэл тавьж, хэлэлцүүлсэн.	100%	100%	
	70		2.. в. Наймдугаар Богд Жавзандамба хутагтын дурсгалд зориулсан кино бүтээх.	БСШУСЯ-ны санхүүгийн дэмжлэгтэйгээр "Сэмүүн" студи Богд хааны амьдрал, үйл ажиллагаа, өв соёлын агуулгатай баримтат кино бүтээж, 2019 оны 12 дугаар сард хүлээлгэн өглөө.	100%	100%	
	71		2.. г. наймдугаар Богд Жавзандамба хутагтын амьдрал, түүхэн замналын талаарх судалгаа, баримтуудыг нэгтгэсэн эмхэтгэл бүтээх.	БСШУССайдын А/535 тоот тушаалаар "Монголын сүүлчийн эзэн хаан Богд Жавзандамба хутагт" номыг хэвлэхэд 6.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн аймаг, нийслэлийн номын санд түгээн уншигчдын хүртээл болголоо.	100%	100%	
29	72	Монгол баатарлаг туульсаа дээдлэн дэлгэрүүлэх тухай	3.. Баатарлаг туульсаа дээдлэн хамгаалах, бүртгэн судлах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, олон улсад сурталчлан таниулах, туульч, өвлөн уламжлагч, өв	Ерөнхий сайдын санаачилсан "Соён гэгээрүүлэх аян"-ы хүрээнд "ДАС ихэр" сан, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран "Монгол ардын Жангар баатарлаг тууль"-ийг хэвлэн нийтийн номын сангийн 376 салбар тус бүрт таван ширхгийг хандивлах арга хэмжээг 11 дүгээр	100%	100%	

		2019-01-29 Дугаар 2019_13	тээгчид болон судлаачдыг урамшуулах үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай.	сарын 18-ны өдөр Үндэсний номын санд зохион байгууллаа.			
	73		4.. Монгол баатарлаг туульсынхаа агуулга, ач холбогдлыг таньж ойлгох, дэмжин дэлгэрүүлэх, өв соёлоо хүндэтгэн дээдлэх, хадгалах, уламжлуулан хамгаалах үйлсэд идэвх санаачлагтай оролцохыг тбрийн ба төрийн бус байгууллага, иргэд олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалсугай.	Монгол Улсын Урлаг, Соёлын гавьяат зүтгэлтэн цуурч, хөөмийч Эрдэнэцогтын Баатаржавын "Дэлхийд түгсэн өв соёл" үзэсгэлэнг Улаанбаатар хотноо Монголын театрын музейд 2019 оны 12 дугаар сард зохион байгуулагдлаа. Үзэсгэлэнд Э.Баатаржавын дэлхийд аялан тоглосон 30 гаруй жилийн бүтээлийг харуулсан гэрэл зураг, альбом, бичсэн ном, хөгжим хэрэгсэл, дүрс бичлэг зэргийг дэлгэн үзүүлж, нийтийн хүртээл боллоо. Э.Баатаржав нь дэлхийн 90 гаруй орноор аялж, туулиа хайлан, очсон орныхоо тууль, домгийг судалж, арвин их судалгаа хийхээс гадна, монгол үндэсний язгуур урлагийг түгээн дэлгэрүүлж, сурталчилсан. Тус үзэсгэлэнгийн үеэр "Аргил цагаан өвгөн", "Баян цагаан өвгөн" хоймсон туулийн эхлэлээс хайлж, үзэгчдэд сонордуулав.	100%	100%	
ҮАБЗ-ийн зөвлөмж							
30	74	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05	1.10. Ерөнхий боловсролын ахлах ангийн сургалтын хөтөлбөрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг ойлгуулан таниулах арга бүхий хичээлийг 2018-2019 оны	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд-ын сайдын 2018 оны А/467 дугаар тушаалаар 6-12 дугаар ангийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг батлан ерөнхий боловсролын нийт сургуульд хэрэгжүүлж эхэллээ. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр нь суралцагчид насан туршийн эрүүл амьдралын хэв маягийн талаарх хувь хүний хариуцлагыг ухамсарлан, өөрийн болон бусдын, цаашлаад хүрээлэн буй	100%	100%	

	Дугаар 2018_06/05	хичээлийн жилээс эхлэн тусган хэрэгжүүлэх.	орчныхоо эрүүл байдлыг хүндэтгэх хандлагыг хөгжүүлэхэд тусална. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр дараах 6 үндсэн агуулгаас бүрдэж байна. Үүнд: 1. Хувийн ариун цэвэр, орчны эрүүл ахуй 2. Хооллолт, хөдөлгөөн 3. Сэтгэцийн эрүүл мэнд 4. Хорт зуршил 5. Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд 6. Осол гэмтэл зэрэг болно. Эрүүл мэндийн хичээл заах багш нарыг давтан бэлтгэж, тэдэнд сургалтын хөтөлбөр, зөвлөмжийг 7000 ширхэг хэвлэж түгээлээ.			
75		1.12. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ил болон далд хэлбэрээр сурталчилсан хэвлэл мэдээллийн байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлах, цахим сайт, хаягуудыг хориглох, ийм төрлийн сэдэвтэй гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, үйлдэх аргыг нарийвчлан харуулсан бүх төрлийн кино, нэвтрүүлэг, нийтлэл болон бусад уран бүтээлийг олон нийтэд хүргэхгүй байх арга хэмжээг тухай бүр авах.	БСШУСЯ-нд Дэд сайдаар ахлуулсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл”-ийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/296 дугаар тушаалаар байгуулан тухайн жилд хийгдэх ажлын төлөвлөгөөг шинэчлэн гаргаж, дэд сайдаар батлуулсан. Уг ажлын хүрээнд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” засгийн газрын тогтоолын агуулгыг багтаан орон нутгийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран үр дүнтэй зохион байгуулан ажиллаж байна.	100%	100%	
76		1.13. Урлаг, спортын сургалт чвуулдаг байгууллагуудад төрөөс татаас өгөх, тэдгээрийг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамруулах зэргээр дэмжиж хүүхэд, залуусын чөлөөт	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 06/05 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор БСШУС-ын сайд "Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах тухай" 2018 оны А/129 дүгээр тушаал гаргасан. Тус тушаалд ахлах ангийн сургалтын хөтөлбөрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мансууруулах эм,	100%	100%	

			цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэлбэрүүдийг санаачилж, хэрэгжүүлэх.	сэтгэцэд нөлөөлөх бодисын хор хөнөөлийг ойлгуулан таниулах агуулга тусгаж батлуулахыг үүрэг болгосон.			
ЗГ-ын тогтоол							
31	77	ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ / Угийн бичиг хөтлөх журам/ 2007-10-03 Дугаар 2007_257	2.. Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай. Хавсралт: 1.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамнаас 2007 оны 257 дугаар тогтоолоор “Угийн бичиг хөтлөх журам”-ыг шинэчлэн батлуулж, мөрдөж байна. Тогтоолд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайдад “Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар”-ыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг даалгасны дагуу Сайдын 2008 оны 75 дугаар тушаал гарч, “Монгол Улсын иргэн угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар”-ыг боловсруулах ажлыг Монгол Улсад хүн судлал, хүн амын генетикийн чиглэлээр шинжлэх ухааны судалгаа хийдэг цорын ганц эрдэм шинжилгээний байгууллага болох “Хүн Судлалын Үндэсний Төв”-тэй гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.	100%	100%	
32	78	Хөтөлбөр батлах тухай 2017-03-20 Дугаар 2017_98	3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо”-нд, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжаар төрийн өмчийн зарим их, дээд сургуулийг Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг, аймаг орон нутагт үе шаттай байршуулах асуудлыг судалж дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. 1.МГАМТИС-ийн өргөтгөл барих ХБНГУ-ын 7 сая еврогийн Зээлийн гэрээний төслийг Сангийн яамнаас Засгийн газар, УИХ-ын холбогдох байнгын хороо дэмжсэн. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдтай байгуулах хэрэгжилтийн гэрээ байгуулахаар төлөвлөж	70%	70%	

				байна. Монголын талаас 2019 онд гарах 504 оюутны дотуур байрны 2,5 тэрбум төгрөг төсөвт суусан ба тендерийн нийслэлээс зарлаж байна. Үлдсэн 10 тэрбум төгрөгийг 2020 оны төсвийн хязгаарт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлж байна.			
	79		4. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	АШУҮИС-ийн 8 бүрэлдэхүүний сургуулиас Анагаах Ухааны сургууль, Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн хичээлийн байр, Монгол уламжлалт анагаах ухааны эмнэлгийн барилгыг барьж дуусаад ашиглалтанд авч, хоёр сургууль шинэ байранд үйл ажиллагаагаа явуулж байна. Хичээлийн байранд цаашид гурван мянга гаруй оюутнууд эрдэм ном үзэн, Монгол уламжлалт анагаах ухааны 62 ортой эмнэлгээр жилд 110 гаруй мянган хүмүүс үйлчлүүлж, эмчилгээ, оношилгоо хийгдэх юм. 2019 онд Монгол Японы сургалтын эмнэлгийн барилгыг ашиглалтад авсан. Мөн 1200 оюутны дотуур байр, хичээлийн С, D блок буюу Сувилахуйн сургууль, Нүүр ам судлалын сургууль, Эм зүйн сургуулиудын байрыг ашиглалтанд оруулах, спорт комплекс, номын сан, соёл урлагийн төвийн байрны зургийн ажлыг эхлүүлж, барих төсөв хөрөнгийн асуудлыг шийдэх мөн багш ажилчдын 250 айлын орон сууцны асуудал, Эрдмийн сургуулийн байр барих ажил үргэлжилнэ.	70%	70%	
33	80	Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого батлах	2.. "Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого"-ын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил	Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанд "Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" эрдэм шинжилгээний ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгох,	100%	100%	

		<p>тухай 2017-09-27 Дугаар 2017_295</p>	<p>бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, хандив, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Чойжилсүрэн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын үүрэг гүйцэтгэгч Г.Чулуунбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>гадаад дотоодын нэр хүндтэй сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн чанар хүртээмжээс хамаарч мөнгөн урамшуулал олгох, шинжлэх ухааны байгууллагууд олсон нэмэлт орлогоо захиран зарцуулах боломжийг олгосон тушаал шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлж ажиллах, шинжлэх ухааны байгууллагуудын нэгдсэн цогцолборын барилга барих асуудлыг хэлэлцүүлж, Засгийн газрын "Төрөөс шинжлэх ухааны талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" 379 дүгээр тогтоолыг баталсан хэрэгжүүлж байна.</p>			
	81		<p>3.. "Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого"-ыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын үүрэг гүйцэтгэгч Г.Чулуунбаатарт үүрэг болгосугай.</p>	<p>"Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2018-2025 он/-ний төслийг боловсруулж, яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, МХАҮТ, төрийн болон хувийн их сургууль, ШУА, эрдэм шинжилгээний байгууллага зэрэг 30 байгууллагаас санал авч тусган Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" 2018 оны А/443 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	100%	100%	
34	82	<p>Үндэсний хөтөлбөр батлах тухай 2017-11-29 Дугаар 2017_321</p>	<p>2.. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг батлуулсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлыг нэг дэд бүлэг болгон тусган оруулсан болно.</p>	100%	100%	

			ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл нарт даалгасугай.	Улмаар тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/116, А/304, А/197 дугаар хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна.			
35	83	Монгол улсын 2018 оны төсвийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн 2018 оны Төсвийн тухай хууль, эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай 2017-12-13 Дугаар 2017_337	5.. “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөр хэрэгжүүлж, анги дүүргэлт хэт өндөр байгаа сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулах, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2018 оны 2 дугаар сард багтаан хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2018 онд ашиглалтад оруулах сургууль, цэцэрлэгийн барилгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, аймаг, нийслэлийн Засаг дарга,	Монгол Улсын 2018 оны улсын төсвийн тухай хуулиар 105 цэцэрлэг шинээр барихад зориулж 72.5 тэрбум төгрөг батлагдсан үүнээс 2018 онд ашиглалтад орох 18.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий 27 цэцэрлэг батлагдсан бол 2965 хүүхдийн хүчин чадалтай 22 цэцэрлэг ашиглалтад орж 81.5 хувийн хэрэгжилттэй байна. Эдгээрээс 2018 онд 12 цэцэрлэг ашиглалтад орж, 2019 онд 7 цэцэрлэг нь ашиглалтад орсон. Улаанбаатар хотод 2016-2017 оны хичээлийн жилд 31 сургууль, 2017-2018 оны хичээлийн жилд 23 сургууль, 2018-2019 оны хичээлийн жилд 20 ерөнхий боловсролын сургууль 3 ээлжээр хичээллэж байгаа бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилд 3 ээлжээр хичээллэж буй бүх сургуулийг 2 ээлжинд шилжүүлэхээр зорилт тавин ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11820 хүүхдийн хүчин чадалтай 26 сургуулийн барилга, Бага сургууль цэцэрлэгийн барилгын цогцолбор 840 хүүхдийн хүчин чадалтай 3 сургуулийн барилга тус тус улсын төсөвт тусгагдсан. Гадаад зээл тусламжийн хөрөнгө оруулалт болох БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар 5680	100%	100%	

			Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай.	хүүхдийн хүчин чадалтай 7 сургуулийн барилга, Япон улсын буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар 2520 хүүхдийн хүчин чадалтай 4 сургуулийн барилга нийт Улаанбаатар хотод 40 сургуулийн барилга ашиглалтад орж сургуулийн барилгын хүчин чадалыг 20860 хүүхдийн суудлаар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 20 сургууль, БНХАУ-ын 4 сургуулийн барилгыг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өмнө ашиглалтад оруулахаар ажиллаж байна. 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 1760 хүүхдийн хүчин чадалтай 6 сургуулийн барилга ашиглалтад оруулаад байна.			
36	84	Аргачлал шинэчлэн батлах тухай “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал” 2018-01-24 Дугаар 2018_20	4.. Хөгжлийн индексийн үр дүнг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлт боловсруулахад ашиглаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, тухайн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн төсөвт олгох хөрөнгийг хөгжлийн индекс ашиглан тодорхойлсон итгэлцүүрийг үндэслэн тооцож байхыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус даалгасугай.	Хөгжлийн индексийн үр дүнг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлт боловсруулахад ашиглах чиглэлээр салбарын хэмжээнд орон нутгаас 2019 оны төсвийн төсөлд саналаа ирүүлэх тухай чиглэлийг өгөөд байна. Боловсролын тухай хуулийн дагуу баг, сум, аймгийн төв, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувьсах зардлыг байршлаас хамааруулан өөр байхаар тогтоож байгаа болно.	30%	30%	
37	85	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	1.. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд шинээр хэрэгжүүлэх төсөл,	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрчимжүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх	100%	100%	

		<p>2018 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн тухай 2018-01-31 Дугаар 2018_34</p>	<p>арга хэмжээг эрчимжүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай: 1.1. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ижил хүчин чадал бүхий төслүүдийг нэг маягийн зургаар хэрэгжүүлж төсөвт өртгийн зөрүүг багасгах; 1.2. нэг маягийн зургаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний холболтын зураг төсөв хийлгэх ажлыг яаралтай зохион байгуулж, нэг маягийн зураггүй төслүүдийг ойролцоо байршил, хүчин чадал бүхий нэг маягийн зурагт холболтын зураг, төсөв хийлгэж хэрэгжүүлэх; 1.3. нэг маягийн зургаар хэрэгжүүлэх боломжгүй төсөл, арга хэмжээний зураг, төсвийг шинээр боловсруулахад шаардагдах зардлыг барилгын ажил гүйцэтгэх гэрээний дүнд оруулан, 2018 оны төсвийн</p>	<p>зорилгоор нэг маягийн зураг төсвийг ашиглаж байна. Одоо ашиглагдаж байгаа нэг маягийн зургууд: дотуур байрны 5 зураг /80 ортой, 100 ортой 2 зураг, 160 ортой, 200 ортой/ сургууль цэцэрлэгийн цогцолборын 4 зураг /250 суудалтай 2 зураг, 280 суудалтай 2 зураг/ цэцэрлэгийн 4 зураг /280 ортой, 150 ортой, 100 ортой, 200 ортой/ сургуулийн 3 зураг /640 суудалтай, 160 суудалтай, 960 суудалтай/, соёлын төвийн 5 зураг /240 суудалтай 2 зураг, 320 суудалтай 2 зураг, 400 суудалтай/ сургуулийн барилгын биеийн тамирын заалны 3 зураг /15x24, 15x30, 24x36 хэмжээтэй/</p>			
--	--	---	--	--	--	--	--

			тухай хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтаан санхүүжүүлэх.				
38	86	“Гурван тулгуурт хөгжлийн бодлого” батлах тухай 2018-02-06 Дугаар 2018_19	3.. “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-д тусгасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, бодлогын хэрэгжилтийг уялдуулан зохицуулж, гүйцэтгэлийн явцыг нэгтгэн жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар тус тус даалгасугай.	“Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын 3.7.1.4, 3.7.3-3.7.5-д тусгагдсан заалтууд амжилттай хэрэгжиж байна. Үүнд: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны орчны стандарт MNS 6558:2015 Шаардлага 5.1.2-т “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эзэмшил газарт гэрэлтүүлэг, камертай байх”-аар заасан. Нийслэлийн төрийн өмчийн 239 цэцэрлэгийн камержуулалтын байдлыг авч үзвэл: 2019 онд 66 цэцэрлэгт 658 камер шинээр суурилуулсны 128 нь гадна орчинд, 529 нь дотно орчны хяналтыг сайжруулахад зориулагдсан байна. Цэцэрлэгийн камержуулалтын ажлыг орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөр, хувийн хэвшлийн байгууллага, иргэд олон нийтийн оролцоотой санхүүжилтийг шийдвэрлэж байна. 2019 оны 5 дугаар сарын 20-ны байдлаар нийслэлийн 6 цэцэрлэгийн /34-4, 262-11, 40 сувилал 5, 48 -1, 91-16, 248-4 бүлэгт/ 41 бүлэгт камергүй байна. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр (хөтөлбөр-сурах бичиг-арга зүй-үнэлгээ)-ийг 10-аас доошгүй жилийн үечлэлтэйгээр боловсронгуй болгох “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал”-ыг боловсруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/549 дүгээр тушаалаар батлуулсан. Сурах бичгийн хангамжийн үр ашигтай загвар болох “Сурах бичгийг төлбөртэй ашиглуулах журам”-ыг батлуулж, 2019-2020 оны	100%	100%	1 дүгээр улирлад багтаан тусад нь тайлагнадаг тул дотоод хяналтандаа авч ЗГХШҮМС-ийн хяналтаас хасуулах.

				хичээлийн жилээс мөрдөнө. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангаж, нэр хүнд, хөдөлмөрийн үнэлэмжийг нь дээшлүүлэх зорилгоор МУ-ын Ерөнхий сайдын ивээл дор Монголын багш нарын 7 дугаар их хурлыг зохион байгууллаа. Гурван тулгуурт бодлогын Олон тулгуурт эдийн засгийн хөгжлийн бодлогын хүрээнд үйлдвэржилтийг дэмжих зорилт тавьж Тэргүүлэх ач холбогдолтой хөтөлбөр /мэргэжил/-ийн жагсаалтыг шинэчлэн Засгийн газрын тогтоол батлуулахаар ажиллаж байна. Энэхүү жагсаалтад малын гаралтай түүхий эд, хүнс боловсруулах үйлдвэрт шаардлагатай инженерийн хөтөлбөрүүд, хүн амын эрүүл мэнд, боловсролын салбарт шаардлагатай хөтөлбөрүүдийг оруулаад байна.			
39	87	Журам шинэчлэн батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай 2018-02-06 Дугаар 2018_46	4.. Оюутны хөгжлийн зээлд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусган санхүүжүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай.	2018 онд 75 тэрбум төгрөг улсын төсөвт тусгаад байна. 2018 оны 1-6 сард Засгийн газраас баталсан тогтоол, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор нийт 18 243 оюутны 9,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийн тооцоог хийж гүйцэтгэв. 2019 онд 33.0 тэрбум төгрөг батлагдсан. Журам шинэчлэн батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төсөл, “Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчдад “Оюутны хөгжлийн зээл” олгох, эргэн төлүүлэх журам”-ын төслийг Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 06-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн 46 дугаар тогтоолыг баталсан. “Оюутны хөгжлийн зээл”-ийг хүүгүй олгохоор болсон бөгөөд жилдээ 35-37 мянган оюутан, суралцагч зээл авах боломж бүрдүүлсэн. Зээлдэгч оюутан хичээлийн жилийн нэг улиралд 10-аас доошгүй	100%	100%	

				цагийн хичээл судалж, дүгнүүлсэн байх ёстой. Хангалтгүй үнэлгээ авсан хичээлийг давтан суралцсан тохиолдолд тухайн багц цагийн хичээлийн төлбөрт зээл олгохгүй. Мөн бакалаврт суралцаж байгаа зээлдэгчийн өмнөх улирлын голч дүн 2.8 болон түүнээс дээш, магистрант, докторант бол голч дүн 3.2 болон түүнээс дээш байх тохиолдолд зээлийг үргэлжлүүлэн олгохоор журамласан. Журам батлагдан гарснаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Оюутан, суралцагчдад үндэсний тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламжийн үйлчилгээг үзүүлэх тогтолцоог ил тод, нээлттэй болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх, оюутан, суралцагчдыг сургалтын төлбөрийн дарамтгүй болгох” гэсэн зорилт бүрэн хэрэгжиж эхэллээ. Боловсролын зээлийн сангаар Оюутны хөгжлийн зээлийн хяналтын тоо батлуулах хяналтын тоог 32,650 аар тогтоож, 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан А/236, 88 тоот тушаалыг батлуулсан.			
40	88	Журам батлах тухай 2018-06-20 Дугаар 2018_184	2.. “Соёлын биет бус өвийн үзлэг хийх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам”-ыг 2 дугаар хавсралт, “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг	Соёлын биет бус өвийн үзлэгийг 2020 онд зохион байгуулахтай холбогдуулан, 21 аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд 2019 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотноо сургалт зохион байгуулж, үзлэг тооллого зохион байгуулах удирдамж, арга зүйг танилцуулан, үзлэг тооллогын бэлтгэл ажлыг хангалаа.	100%	100%	

			Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаад даалгасугай.				
41	89	Хөтөлбөр батлах тухай 2018-07-04 Дугаар 2018_209	2.. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2018 оны 3 дугаар улиралд багтаан хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа нарт тус тус даалгасугай.	“Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/372, А/610 дугаар тушаалаар баталсан. Төлөвлөгөөний хүрээнд тогтвортой хөгжил-ногоон байгууламж, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг Улсын тэргүүний цэцэрлэг шалгаруулах үйл ажиллагаанд шалгуур үзүүлэлт болгон тусгах, цэцэрлэгийнхээ үзэл баримтлалд тусган ажиллаж байгаа цэцэрлэгийн туршлагыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Мөн Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулах ажлын хүрээнд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих суралцахуйн чиглэл бүрд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаа, агуулга, арга зүй, үнэлгээг тусгах ажлыг бие даасан шалгуур үзүүлэлт болгон ажиллаж байна. • Бага, дунд, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг “Тогтвортой хөгжлийн боловсрол”-ын үзэл санааг тусган боловсруулж, шинэчилсэн. Нийтдээ 160 гаруй сургалтын хөтөлбөрийг шинэчлэн ерөнхий боловсролын нийт сургуульд хэрэгжүүлж байна. • Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаанд болон багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх чиглэл, шаардлагыг хэрэгжүүлж	100%	100%	

				байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, сурах бичигт тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусгахад тавих шаардлага, тогтвортой хөгжлийн төлөөх сургуулиудын сүлжээ, хамтын ажиллагаанд тавих шаардлагыг тогтоосон юм.			
	90		3.. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгах, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Тогтвортой хөгжлийн боловсрол Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Үндэсний дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах тухай” 2018 оны А/372, А/610 дугаар тушаалаар “Тогтвортой хөгжлийн боловсрол” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлууллаа. Тус тушаалаар хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус Үндэсний дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний дүрмийг тус тус баталлаа. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг БОАЖЯ, БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нарт тус тус үүрэг болгосон.	100%	100%	
42	91	Цаатан иргэдийн талаар авах арга хэмжээний тухай 2018-07-04 Дугаар 2018_213	3.. Үндэсний цөөнхийн түүх, ёс заншил, өв соёлыг хадгалж үлдэх, эх хэлээрээ суралцах эрхийг хангах зорилгоор тува хэлний сургалтын хөтөлбөрийн	Хос хэлээр сургалтын бүрэн дунд боловсролын эх хэл (казах, тува)-ний сургалтын жишиг хөтөлбөр боловсруулалт дуусаад эхийг хэвлүүлэхээр эх бэлтгэлд хүлээлгэн өгсөн. Тува хэлний хөтөлбөрт үндэслэн “Тува хэл 6” 6 дугаар ангийн гарын авлагыг боловсруулж	100%	100%	

			хэрэгжилтийг эрчимжүүлэх, тува хэлний багш нар бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд С.Цогзолмаад даалгасугай.	байна.			
43	92	Төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2018-07-09 Дугаар 2018_220	6.. Боловсрол, соёл, эрүүл мэнд, спортын байгууллагуудын барилгын засварын ажлыг хугацаанд нь чанартай хийж дуусгах талаар холбогдох арга хэмжээ авч, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд их засварын 62 төсөл арга хэмжээнд 4.0 тэрбум батлагдсанаас мөн хэмжээгээр худалдан авах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг хэрэгжүүлж буй байгууллагаар авч үзвэл: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны хэмжээнд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны явц 98.8%, Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хувьд 93.7%, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 100%, Орон нутагт эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ 100% хэрэгжсэн байна.	100%	100%	
44	93	Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого батлах тухай 2018-08-01 Дугаар 2018_233	2.. “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаад даалгасугай.	Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогын 6 дугаар хавсралтад үндэслэн 4 зорилт, зорилтыг хэрэгжүүлэх 25 үйл ажиллагааны хүрээнд бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж, БСШУС-ын сайдын 2019 оны “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” А/145 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. Уг	100%	100%	

				арга хэмжээг 2020-2025 он хүртэл хэрэгжүүлэхэд Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогын 2 дугаар хавсралтад заасан 1 их наяд 692 сая төгрөгийг зарцуулах тул холбогдох тооцоо судалгааг хийж, 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг 2020 оны төсөвт суулган батлуулсан.			
	94		3. . “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого”-ын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад, дотоодын болон олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогын 6 дугаар хавсралтад үндэслэн 4 зорилт, зорилтыг хэрэгжүүлэх 25 үйл ажиллагааны хүрээнд бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж, БСШУС-ын сайдын 2019 оны "Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" А/145 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. Уг арга хэмжээг 2020-2025 он хүртэл хэрэгжүүлэхэд Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогын 2 дугаар хавсралтад заасан 1 их наяд 692 сая төгрөгийг зарцуулах тул холбогдох тооцоо судалгааг хийж, 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг 2020 оны төсөвт суулган батлуулсан.	100%	100%	
45	95	Үндэсний хөтөлбөр батлах тухай 2018-08-08 Дугаар 2018_241	2.. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	"Соёлын биет бус өвийг хамгаалах" үндэсний хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны "Төлөвлөгөө батлах тухай" А/235 дугаартай тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Мөн уг тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар	100%	100%	

		Ц.Цогзолмаа, орон нутгийн хэмжээнд дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Чиглэл хүргүүлэх тухай" 2019.03.25-ны 1а/2210 тоот албан бичгээр тухайн орон нутгийн өв соёлын онцлогт тохирсон дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх арга хэмжээ авах талаар чиглэл хүргүүлээд байна.				
	96	3.. "Сонгодог урлаг-III" хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тус тус тусгаж, олон улсын байгууллага, гадаадын зээл тусламжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээг авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа нарт үүрэг болгосугай.	"Сонгодог урлаг-III" үндэсний хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг боловсруулан БСШУС-ын сайдын 2019 оны "Төлөвлөгөө батлах тухай" А/236 дугаартай тушаалаар батлуулаад байна. Мөн уг тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар БСШУС-ын сайдын "Чиглэл хүргүүлэх тухай" 2019.03.25-ны 1а/2210 тоот албан бичгээр тухайн орон нутгийн өв соёлын онцлогт тохирсон дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх арга хэмжээ авах талаар чиглэл хүргүүлээ. Үндсэн чиглэл болон 2019 он төсвийн хүрээний мэдэгдэлд холбогдох зардлыг тусгаж Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсөв нэмж батлагдаагүй. 2019 оны улсын төсөвт 115.0 сая төгрөг батлагдсан. 2020 оны төсвийн хүрээний мэдэгдлийн саналд тусган Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2019 оны 1а/3086 тоот албан бичгээр, Сангийн сайдад хүргүүлсэн.	100%	100%		
46	97	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018-08-22 Дугаар 2018_267	8.. Малын генетик нөөцийн тухай хуульд нийцүүлэн мал зүйч мэргэжилд хамаарах мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн батлахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн	Малын генетик нөөцийн тухай хуулийн өөрчлөлтийн дагуу сум бүрт малын эмч ажиллуулах шаардлагын дагуу ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуулиас шаталсан болон түр сургалтуудыг зохион байгуулж мал эмнэлгийн чиглэлээр өмнө төгссөн иргэдийг хамруулан ажлын байртай болгох, малын эмч нарыг мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулах ажлыг үе шаттай хийж байна. Мөн хуулийг	30%	70%	

			<p>Үйлдвэрийн сайд Б.Батзориг нарт үүрэг болгосугай.</p>	<p>даган гарах дүрэм, журмуудад санал өгч хамтран ажиллаж байна. Хөдөө, аж ахуйн чиглэлийн мэргэжил, хөтөлбөрийн индекс дээр нэмж Мах, сүү судлал, хөдөө аж ахуйн таваар судлал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, малын эмч, хөдөө аж ахуйн кибернетик хөтөлбөрийг оруулж байна.</p>			
47	98	<p>Үндэсний хөтөлбөр батлах тухай 2018-09-05 Дугаар 2018_282</p>	<p>2.. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хүрээнд холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай шийдвэрийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаад даалгасугай.</p>	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах, зардал батлах тухай" А/443 тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын бүтэц зохион байгуулалт, сургалт, судалгааны ажлын чанарыг судлан санал боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсгээс төрийн өмчийн их дээд сургуулиудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох замаар дэлхийн хэмжээний судалгааны их сургууль байгуулах үзэл баримтлалыг боловсруулсан бөгөөд Засгийн газрын хурал, Нийгмийн бодлого, боловсрол, шинжлэх ухааны байнгын хорооны хурлаар хэлэлцүүлсэн. Тус хуралд төрийн болон төрийн бус өмчийн их сургуулиуд, мэргэжил, арга зүйн байгууллага, мэргэжлийн холбоод, судлаач багш нарын төлөөл бүхий 120 орчим хүн оролцсон.</p>	100%	100%	
	99		<p>3.. Үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт</p>	<p>Үндсэн чиглэл болон 2019 он төсвийн хүрээний мэдэгдэлд холбогдох зардлыг тусгаж Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсөв нэмж батлагдаагүй. 2020 оны төсвийн хүрээний мэдэгдлийн саналд тусган БСШУС-ын сайдын 2019 оны 1а/3086 тоот албан бичгээр, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх хэсэгт заасны дагуу Дээд боловсрол салбарын урсгал</p>	100%	100%	

			тусгаж, олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа нарт үүрэг болгосугай.	төсвийн 2019 оны хязгаарын саналд тусган БСШУС-ын сайдын 2019 оны 1а/5282 тоот албан бичгээр тус тус Сангийн сайдад хүргүүлсэн. Судалгаанд суурилсан их сургууль үндэсний хөтөлбөр батлан, хэрэгжүүлэх. /Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.18. Төрийн өмчит их, дээд сургууль, коллежийг хувьчлахгүй. Дээд боловсролын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, төрийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг нь хангах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Боловсролын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах саналд судалгааны их сургууль байгуулах тухай заалт тусгагдсан./ -2.0 тэрбум төгрөг шаардлагатай.			
48	100	Дэлхийн өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаа байгуулах тухай 2018-10-03 Дугаар 2018_299	3.. Хамгаалалтын захиргааны үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг 2020 оны улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай.	2020 оны улсын төсөвт хамгаалалтын 2 захиргааны үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг баталсны дагуу хамгаалалтын захиргааны дүрмийг Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Хамгаалалтын захиргааны үйл ажиллагааг эхлүүлэхээр хуулийн этгээдэд бүртгүүлэх, захиргааны дүрмийг боловсруулах, даргыг сонгон шалгаруулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.	100%	100%	
	101		4.. Хамгаалалтын захиргааны үйл ажиллагааг эхлүүлэх хүртэлх хугацаанд	Хамгаалалтын захиргаа байгуулагдтал хамгааллын үйл ажиллагааг Монгол Алтайн нурууны болон Хан Хэнтийн тусгай	100%	100%	

			түүний чиг үүргийг Монгол Алтайн нурууны болон Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд тус тус түр хариуцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа нарт даалгасугай.	хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд түр хариуцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.			
49	102	2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгох тухай 2019-01-16 Дугаар 2019_23	3. Хавсралтаар төлөвлөгөөг оруулав.. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. Жич: Хавсралтаар оруулсан “ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-ний дагуу өөрийн нэр заасан ажлыг хүснэгтээр гаргаж	“ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-ний Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгайлан гаргаж БСШУС-ын сайдаар батлуулан хэрэгжилтийг улирал бүр тайлагнан ажиллаж байна. 2019 оны жилийн эцсийн хэрэгжилт 84 хувьтай байна.	100%	100%	

			тайлагнана.				
50	103	Дүрэм батлах тухай 2019-01-23 Дугаар 2019_33	2.. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хууль, "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-д нийцүүлэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж байна.	70%	70%	
51	104	2019 оныг "Эх оронч худалдан авалтын жил" болгох тухай 2019-01-30 Дугаар 2019_59	3.. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хагас болон жилийн эцсийн байдлаар Аж үйлдвэржилтийн бодлогын зөвлөлд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.	Эх оронч худалдан авалтын жилийн хүрээнд "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 81 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтад заасан "Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал"-ын дагуу тооцно" гэж заасныг баримтлан худалдан авах ажиллагааг зохион байгуулж, дотоодод үйлдвэрлэх боломжтой ширээ, сандал, тавилга, сурах бичиг гэх мэт ажлуудад гадаадын этгээд оролцохыг хориглосон заалт оруулан тендер шалгаруулалтыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн БСШУС-ын сайдын 2019 оны А/106 тоот "Эх оронч худалдан авалтын жил"-ийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай тушаал гарч энэ дагуу салбарын худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан. Монгол улсын хэмжээнд 2019 оны төсөвт боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад үндэсний компани болох гал тогооны тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг Чиглэл ХХК, сурагч ширээ сандал үйлдвэрлэдэг Долоон болдог ХХК-ны бүтээгдэхүүнийг давуу эрхтэйгээр сонгож байна.	100%	100%	

52	105	<p>Үндэсний хөтөлбөр батлах тухай 2019-02-13 Дугаар 2019_68</p>	<p>3.. “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын төсвийн багцад жил бүр тусган, олон улсын байгууллага, гадаадын зээл тусламжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нарт даалгасугай.</p>	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд ЮНЕСКО болон Швейцарийн хөгжлийн сан, Соёл, урлаг дэмжих сан болон бусад байгууллагын санхүүгийн дэмжлэг авч, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг улсын төсөв, олон улсын байгууллагын тэтгэлэг, тусламжид тулгуурлан зохион байгуулж байна. Энэ хүрээнд 2019 онд соёлын биет бус өвийн чиглэлээр нийт 10 гаруй нэр төрлийн 20 орчим төсөл хөтөлбөр хэрэгжээд байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг 21 аймаг, нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлсэн нийт ажил арга хэмжээний нэгдсэн тайланг боловсруулан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэхэд бэлэн болголоо.</p>	100%	100%	
53	106	<p>Үндэсний хөтөлбөр батлах тухай 2019-02-13 Дугаар 2019_69</p>	<p>2.. “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт үүрэг болгосугай.</p>	<p>Засгийн газрын 2019 оны "Үндэсний хөтөлбөр батлах тухай" 69 дүгээр тогтоолоор "Чулуун соёлын өв" хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг БСШУС-ын сайдын 2019 оны 6 сарын 05-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" А/368 тоот тушаалаар батлуулж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Соёл, урлагийн газар болон Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу 2019 онд Чулуун соёлын өвийг бүртгэх арга зүйг шинээр боловсруулах, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших Уушигийн өврийн буган чулуун хөшөө бүхий цогцолбор, Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт орших Их Жаргалантын буган чулуун хөшөө бүхий цогцолбор, Архангай аймгийн Ихтамир сумын</p>	100%	100%	

				<p>нутагт орших Тайхар чулууг кадастрын бүртгэлд бүртгүүлэх, Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Баруун элгэний бичээс, Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уулын хадны зураг, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Жаргалантын ширээний хадны зургийн хэв хуулбар, дардсыг авч хадгалах, Хөтөч тайлбарлагчдад зориулсан сургалт зохион байгуулах гэсэн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, өнөөдрийн байдлаар 100 %-ийн гүйцэтгэлтэй байна. Мөн 2019-2020 онд хэрэгжүүлэхээр 5 арга хэмжээг төлөвлөж, эхлүүлээд байна.</p>			
54	107	<p>Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай 2019-02-27 Дугаар 2019_87</p>	<p>4.. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Боловсролын зээлийн сан, Улсын авто замын сангийн талаар дараахь арга хэмжээг авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан нарт тус тус даалгасугай.</p>	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А/124 дүгээр тушаалаар баталсан ажлын хэсэг Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, салбарын бодлого шийдвэрийн хэрэгжилттэй танилцаж, зөвлөмж өгсөн. Тус ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн "Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох" журмыг батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл боловсруулан яамдын саналыг 2 удаа авсан. УИХ-ын тогтоолын үзэл баримтлалын төсөл, судалгааны тайлан, журмын төслийг ХЗДХЯ, СЯ руу 12 дугаар сард явуулаад байна. Мөн 2019 оны 05 дугаар сарын 9-ний Оюутны хөгжлийн зээл олгох хяналтын тоог БСШУССайд, Сангийн сайдын хамтарсан</p>	100%	100%	

				тушаалаар батлуулан 11 000 оюутанд суралцагчдад 33 тэрбум төгрөгийн зээл олгохоор батлуулан хэрэгжүүлж байна. БМИҮЗ-ийн 1,6 тэрбум төгрөгийн зээлийн квотыг нэмэгдүүлэх хамтарсан тушаалын төслийг СЯ руу 12 дугаар сард хүргүүлээд байна. Боловсролын зээлийн санд сургалтын чиглэлээр үүссэн авлагын нөхцөл байдлын судалж, нягтлан бодох бүртгэлийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, санал гаргах ажлын хэсгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/379 дугаар тушаалаар байгуулан ажиллаж, сургалтын дүрэм журмыг боловсруулж байна.			
55	108	Сурах бичгийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-03-06 Дугаар 2019_98	1.. Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдыг сурах бичгээр бүрэн хангах зорилгоор сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээг ерөнхий боловсролын сургуулиудад нэвтрүүлэх, энэ үйл ажиллагаанаас хуримтлагдсан орлогын хүрээнд дунд, ахлах ангийн сурах бичгийн хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэн нийлүүлэх, төлбөртэй ашиглуулах үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх, холбогдох журам, аргачлалыг баталж мөрдүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан,	“Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам”-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн А/302 дугаар тушаалаар, “Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчдад тухайн ангийн сурах бичгийг сургуулийн номын сангаар дамжуулан хичээлийн жилийн турш төлбөртэй ашиглуулах төлбөрийн хэмжээ”-г мөн сайдын 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/624 дүгээр тушаалаар батлан ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлээд байна. Ерөнхий боловсролын сургуулийн VI-XII ангийн 178,719 сурагчид төлбөртэй ашиглуулахаар VI, VII ангийн 29 нэрийн 1,042,000 ширхэг, VIII, IX ангийн 34 нэрийн 946,000 ширхэг, X-XII ангийн 35 нэрийн 747,030 ширхэг сурах бичгийг сургуулийн номын санд нийлүүллээ. Үүний үр дүнд ерөнхий боловсролын сургуулийн	100%	100%	

			спортын сайд Ё.Баатарбилэгт үүрэг болгосугай.	сурагчид сурах бичгээр бүрэн хангагдсан.			
	109		2.. Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад төлбөртэй ашиглуулах сурах бичиг хэвлүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх боломжийг судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нарт даалгасугай.	Азийн хөгжлийн банкны туслалцаатай хэрэгжүүлж буй "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд 3.1 сая ам долларыг санхүүжүүлэхээр харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан болно.	100%	100%	
56	110	Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2019-03-21 Дугаар 2019_111	2.. Бүх шатны төсвийн байгууллага, төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.	БСШУС-ын салбарт 2018 оны байдлаар нийт 97.4 мянган хүн ажиллаж байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй 1.3 мянган хүн ажил эрхлэж байгаа судалгаа гарсан бөгөөд БСШУС-ын салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг илүүтэй дэмжиж ажиллаж байна.	70%	70%	
57	111	Хөгжлийн	2.3. . Хөгжлийн бэрхшээлтэй	СӨББ-д эхний болон тав, арав дахь жилдээ	100%	100%	

		<p>бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв байгуулах тухай 2019-04-03 Дугаар 2019_125</p>	<p>хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд ажиллах хүний нөөцийг бэлтгэх, сургалт зохион байгуулах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нарт;</p>	<p>ажиллаж буй багш, ажилтанд зориулсан үндсэн сургалтад нийт 1,316 багш, арга зүйч, эрхлэгч хамрагдсан бөгөөд сургалтын хөтөлбөрт “Хэлний бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, оролцоо, хөгжлийг дэмжих” арга зүй сэдвийг сургалтын хөтөлбөрт тусган заалаа. 17 аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар БМДИ, СӨБ-ийн сургууль зэрэг 8 байгууллагатай хамтран "Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт /нийгмийн загвар/", "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга барил" ,"Хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлд нь хөгжлийг дэмжих Портеж хөгжлийн зориулалт, ажиллах арга зүй” сэдвээр 1,584 багш, туслах багш, эцэг эхэд зориулсан сургалтыг 4,9 сая төгрөгний санхүүжилтээр зохион байгуулсан. 2019-2020 оны хичээлийн жилд Тэгш хамруулан сургах боловсрол онлайн курст 2137 багш, сургалтын байгууллагын удирдах ажилтан хамруулан мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүллээ. “Тусгай хэрэгцээт боловсрол-Багшлах аргазүй” 24 цагийн сонголтот сургалтад сургууль, хүүхэд хөгжлийн төв, төрийн бус байгууллагын 23 багш хамрагдан батламж авлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын дэмжлэг үзүүлэх чиглэлээр “Сэтгэцийн эрүүл мэнд”, “ICF”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах арга зүйд сургах нь”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, нөхөн сэргээх, засан сайжруулах, ахуйн баримжаа олгох” зэрэг цуврал сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 200 орчим багш, эцэг эх хамрагдлаа. Ерөнхий боловсролын 55</p>			
--	--	---	--	---	--	--	--

				дугаар тусгай сургуулийн 3 багшийг Унгар Улсад, 29 дүгээр сургуулийн 3 багшийг ОХУ-ын Санкт-Петербург хотод мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах ажлыг зохион байгууллаа.			
58	112	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай 2019-04-03 Дугаар 2019_126	2.. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтанд олгох нэмэгдэл хөлсийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд жил бүрийн батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтанд олгох нэмэгдэл хөлсийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шинэчлэн тогтоож 2020 оны төсвийн төсөлд тусган БСШУС-ын сайдын 2019 оны 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлж, 2020 оны төсөвт дараах дүнгээр батлагдсан байна. Үүнд: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын цалингийн зардал 79.7 тэрбум, НДШ 12.9 тэрбум төгрөгөөр; Ерөнхий боловсролын сургуулийн нийт цалингийн зардал 96.8 тэрбум, НДШ 18.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2020 оны төсөвт батлагдсан.	100%	100%	
59	113	Монгол Улсын хилээр хууль бусаар гаргасан палеонтологийн олдвор болох Протоцератопс болон Тарбозавр үлэг гүрвэлийн хэлхээ яс, Протоцератопс, Тарбозавр болон Хадрозавр үлэг гүрвэлийн зарим чулуужсан яс, Триннозавр Батаар үлэг гүрвэлийн гавлын ясыг Америкийн Нэгдсэн Улсаас эргүүлэн авчрах, холбогдох музейд Хадрозавр үлэг гүрвэлийн зарим чулуужсан яс, Триннозавр	1.. Монгол Улсын хилээр хууль бусаар гаргасан палеонтологийн олдвор болох Протоцератопс болон Тарбозавр үлэг гүрвэлийн зарим чулуужсан яс, Триннозавр Батаар үлэг гүрвэлийн гавлын ясыг Америкийн Нэгдсэн Улсаас эргүүлэн авчрах, холбогдох музейд хүлээлгэн өгөх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг Боловсрол,	Монгол Улсын хилээр хууль бусаар гаргасан палеонтологийн олдвор болох Протоцератопс болон Хадрозавр үлэг гүрвэлийн зарим чулуужсан яс, Триннозавр батаар үлэг гүрвэлийн гавлын ясыг Америкийн Нэгдсэн Улсаас эргүүлэн авчрах тухай Засгийн газрын 2019 оны 141 дүгээр тогтоол гаргаж, палеонтологийн олдворыг эргүүлэн авчрах зардалд 157,0 сая төгрөгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас шийдвэрлэлээ.	70%	70%	

		Батаар үлэг гүрвэлийн гавлын ясыг Аме 2019-04-10 Дугаар 2019_141	соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.				
60	114	Чингис хааны өв, соёлын хүрээлэн байгуулах тухай 2019-04-10 Дугаар 2019_142	2.. Тус хүрээлэнгийн бүтэц, орон тоог баталж, үйл ажиллагааг нь 2019 онд багтаан эхлүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт, 2020 оноос эхлэн хүрээлэнгийн үйл ажиллагааны зардлыг улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай.	БСШУС-ын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/533 тоот тушаалаар Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн бүтэц, орон тоо, дүрмийг тус тус батлуулж, хүрээлэнгийн үйл ажиллагааны хэвийн, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлээд байна. Засгийн газрын 2019 оны 142 дугаар тогтоолын дагуу Чингис хааны өв, соёлын хүрээлэн байгуулан 2019 оны 9 дүгээр сараас үйл ажиллагааг эхлүүлсэн байна. Тус хүрээлэнгийн 2019 оны үйл ажиллагааны зардлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын батлагдсан төсвөөс гарган үйл ажиллагааг эхлүүлсэн. УИХ-аар хэлэлцэгдэж байгаа 2020 оны төсвийн төсөлд хүрээлэнгийн үйл ажиллагааны зардал 921.8 сая төгрөг туссан байна.	100%	100%	
61	115	Олон улсын уралдаан зохион байгуулах тухай 2019-04-10 Дугаар 2019_143	2.. Олон улсын уралдааныг тухайн жилийн төсөвтөө багтаан зохион байгуулж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт үүрэг болгосугай.	Олон улсын уралдааныг тухайн жилийн төсөвтөө багтаан зохион байгуулж байхыг Боловсрол, соёл, шинж	100%	100%	
62	116	Багшийн хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай	2.. Багшийн хөгжлийг дэмжих зорилгоор дараахь арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	"Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам"-ыг боловсруулсан.	30%	70%	

	2019-04-12 Дугаар 2019_145	<p>Ё.Баатарбилэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай: 2.1. хичээл практикийн үйл ажиллагааны зардал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа ердийн сургууль, цэцэрлэгийн багшид 2019 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн урамшил олгох асуудлыг судалж шийдвэрлэх; 2.2. багшийн ажлын онцлогт нийцүүлж үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлэх, багшийн ажлын норм, нормативаас давсан ачаалалд нэмэлт хөлс олгох асуудлыг судалж, үе шаттайгаар шийдвэрлэх санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулах.</p>				
117		<p>3.. Боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт оруулах ажлыг зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Эрүүл</p>	<p>Багш нарын VII их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэн боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт оруулах талаар асуудлаар Эрүүл мэндийн яамтай хамтран ажиллах хүсэлт хүргүүлж, 1а/3252 албан бичгээр хариу авч, нийт багш нараа эрүүл мэндийн үзлэгт оруулах ажлыг зохион</p>	70%	70%	

		мэндийн сайд Д.Сарангэрэл нарт даалгасугай.	байгуулж байна.			
118		4.. Дээд боловсролын болон Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багшийн хөгжлийн төвийг тус тус төсөвтөө багтаан энэ оны 2 дугаар улиралд байгуулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын 145-р тогтоолд заасны дагуу БСШУСС-ын 2019 оны А/235, А/754 дүгээр тушаалуудаар ажлын хэсэг байгуулж, тус багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн дүрмийг боловсруулах 5 дэд ажлын хэсгийг байгуулан ажилласан. Тус ажлын хэсгийн гишүүдийг чадавхижуулах, туршлага судлуулах зорилгоор Хонконгийн их сургуулийн зуны сургалтад хамруулсан. Багшийн хөгжлийг дэмжих төвийг байнгын тогтмол үйл ажиллагаатай байлгах үүднээс тус төвд ажиллах багийг нээлттэй зарлан сонгон шалгаруулсан. Монгол Улсын хэмжээнд дээд боловсролын Багшийн хөгжлийг дэмжих төвтэй болсноор нэгдсэн системтэй, удирдлага зохион байгуулалтаар хангах, багшийн стандарт боловсруулах, багшийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, багшлахуй, суралцахуйд идэвхтэй сургалтын аргыг нэвтрүүлэх, сургалтад инноваци, технологи нэвтрүүлэх, судлаач багшийг хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Дээд боловсролын сургалтын 94 байгууллагаас бие даасан Багшийн хөгжлийн төвтэй 54 байгууллага байгаа ба 18 байгууллага нь хариуцсан мэргэжилтэнтэй ажиллаж байна. Цаашид багшийн хөгжлийн төвүүдийг нэгдсэн удирдлагаар хангах, техник тоног төхөөрөмжөөр хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, дээд боловсролын сургалтын байгууллагын багшийг хөгжүүлэхэд чиглүүлэн ажиллана.	70%	70%	
119		5.. Цахим засаглал үндэсний	Ерөнхий боловсролын сургуульд хэрэглэж	100%	100%	

			хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын багш нарыг компьютержуулах, сургалтын зарим үйл ажиллагааг нь цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээг улсын төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр үе шаттай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай.	байгаа I-XII ангийн бүх сурах бичгийг цахим хэлбэрээр www.econtent.edu.mn , www.meds.gov.mn веб хуудсанд байршуулж, хэрэглэгчдэд нээлттэй ашиглуулж байна. Мөн андройд, ios үйлдлийн системтэй төхөөрөмжөөр сурах бичгийг ашиглах аппликейшн бий болгосон. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид сурах бичгийг тохиромжтой хэлбэрээр ашиглах боломжийг бий болгох чиглэлээр холбогдох төрийн бус байгууллагуудыг дэмжин хамтран ажиллаж байна. Харааны бэрхшээлтэй сурагчдад зориулан 1-3 дугаар ангийн сурах бичгийг брайль болон томруулсан үсгээр хослуулан хэвлэх талаар Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ-тай, Ерөнхий боловсролын сургуулийн I-XII ангийн сурах бичгүүдийг DAISY E-pub хүртээмжид форматад шилжүүлж хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэд бусдын адил ашиглах боломжтой болгох талаар "Хараагүй хүмүүсийн инноваци хөгжлийн төв" ТББ-тай хамтран ажиллаж байна.			
63	120	Хууль сахиулахын их сургуулийг өөрчлөн зохион байгуулах тухай 2019-04-17 Дугаар 2019_152	3.. Дотоод хэргийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулга, чанарыг дээшлүүлэх, багшлах бүрэлдэхүүнийг чадваржуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Хууль сахиулахын их сургуулийг өөрчлөн зохион байгуулах тухай" 152 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Мэргэжлийн чиглэл, индекст өөрчлөлт оруулах тухай" 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/336 дугаар тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг сайжруулж мэргэжлийн индексийг шинэчлэн баталсан баталсан. Сайдын тушаалын дагуу Дотоод хэргийн их сургуулийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг өөрчлөн олгосон.	100%	100%	

			Ё.Баатарбилэг нарт үүрэг болгосугай.	Тус тушаалын 2 дахь заалтын хүрээнд "Бакалаврын хөтөлбөр бүрээр сургалтын төлөвлөгөөг боловсруулан" ДХИС-ийн захирлын 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн Б/104 дүгээр тушаалаар баталгаажуулан 2019-2020 оны хичээлийн ижлийн эхнээс мөрдөн ажиллаж байна.			
64	121		2.. “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.	“Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг БСШУС-ын сайдын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/827 дугаар тушаалаар батлуулсан.	100%	100%	Хяналтаас хасуулах.
	122	Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого батлах тухай 2019-04-17 Дугаар 2019_153	3.. “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, улс, орон нутгийн төсөв, гадаад, дотоодын зээл тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар Биеийн тамирын салбарт нийт 56.6 тэрбум төгрөг үүнээс 12.8 тэрбум төгрөг нь урсгал төсөв, 43.7 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын төсөвт батлагдсан нь Дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ий 0.2%, улсын төсвийн орлогын 0.6%-ийг эзэлж байна. Засгийн газрын тогтоол шийдвэрийн дагуу жил бүр зохион байгуулагддаг спортыг дэмжих арга хэмжээний зардалд 2.0 тэрбум төгрөг зарцуулагдахаар батлагдсан.	100%	100%	

65	123	<p>Үндэсний хөтөлбөр батлах тухай 2019-04-23 Дугаар 2019_162</p>	<p>2.. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт үүрэг болгосугай. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган, олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нарт даалгасугай.</p>	<p>“Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 162 дугаар тогтоолоор батлав. Хөтөлбөрийг 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Тус төлөвлөгөөний төсөлд санал авахаар эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиудаас санал авахаар хүргүүлээд байна. 2019 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийн санхүүжилт батлагдаагүй тул 2020 оны МУЭЗНХҮЧ болон 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэлд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад улсын төсвөөс зарцуулах төсвийн саналыг тусган оруулсан боловч УИХ-аар баталсан 2020 оны Төсвийн тухай хуульд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөрөнгө батлаагүй болно. МУ-ын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор зохион байгуулсан Шинжлэх ухааны ажилтны улсын анхдугаар их хуралд “Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийн хөгжил” салбар хуралдаан зохион байгуулж түүнээс гарсан зөвлөмжийг үндэслэн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан. “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/826 дугаар тушаалаар батлууллаа. “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, 5-</p>	100%	100%	<p>Үндэсний хөтөлбөрийг тусад нь тайлагнадаг тул тухай бүр нь дотоод хяналтанд авч ҮГХШҮМС-ийн хяналтаас хасуулж байх.</p>
----	-----	--	---	---	------	------	--

				р хавсралтаар “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын дагуу ур чадвар, мэргэшлийн зэрэгт тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулан газрын хурлаар хэлэлцүүлэв. Хурлаас гарсан саналыг тусган боловсруулж ТЗУГ-т хүргүүлэн нэгдсэн санал тусгуулан ХНХЯ-нд хүргүүлсэн болно.			
66	124	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-05-01 Дугаар 2019_183	1.. Төрийн бус өмчийн цэцэрлэгт түшиглэсэн салбар бүлгээр нэмэлт элсэлт авах ажлыг зохион байгуулж, шаардагдах зардлыг батлагдсан төсөвтөө багтаан өмчлөгчтэй хэлцэл хийсний үндсэн дээр хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт үүрэг болгосугай.	Нийслэлд анги дүүргэлт өндөр байгаа цэцэрлэгүүдийн ачааллыг бууруулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" А/16 тоот захирамжаар 7 дүүргийн төрийн бус өмчийн 130 цэцэрлэгт 2019-2020 оны хичээлийн жилд нэмэлт элсэлтээр 3087 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна. 2020 онд энэ тооны хүүхэд төрийн бус өмчийн цэцэрлэгт боловсрол эзэмших боломжоор хангагдахаар 2020 оны төсвийн хуульд батлагдаад байна.	100%	100%	
	125		3.. Салбар бүлэг болон зуны цэцэрлэг ажиллуулах мэргэжлийн багш, хүний нөөцийг бэлтгэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Нийслэлд анги дүүргэлт өндөр байгаа цэцэрлэгүүдийн ачааллыг бууруулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" А/16 тоот захирамжаар 7 дүүргийн төрийн бус өмчийн 130 цэцэрлэгт 2019-2020 оны хичээлийн жилд нэмэлт элсэлтээр 3087 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна. 2020 онд энэ тооны хүүхэд төрийн бус өмчийн цэцэрлэгт боловсрол эзэмших боломжоор хангагдахаар 2020 оны төсвийн хуульд батлагдаад байна.	100%	100%	

	126		<p>2.. Иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөлд байгаа цэцэрлэгийн зориулалттай барилгыг түрээслэхэд шаардагдах зардлыг суурь судалгаанд тулгуурлан улсын төсөвт тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нарт даалгасугай. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Цэцэрлэгийн хүрэлцээг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 40 дүгээр тогтоолын 4 дүгээр заалтыг хүчингүй болсонд тооцсугай.</p>	<p>Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах зорилгоор 2019 онд “Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 183 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн боловсролын газраас ирүүлсэн судалгаанд үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн "Барилга түрээслэх тухай" А/522 дугаар тушаалаар нийслэлийн анги дүүргэлт хэт өндөртэй байгаа 4 дүүрэг (Баянзүрх, Хан-уул, Сонгинохайрхан, Налайх)-ийн 8 цэцэрлэг (22, 35, 40, 49, 63, 140, 188, 256)-ийн 28 бүлгийн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөлийн 840 хүүхдийн хүчин чадалтай барилгыг түрээслэн, сургалтын үйл ажиллагаа явуулахаар батлагдсан. Цэцэрлэгийн зориулалтын барилгыг түрээслэх арга хэмжээнд улсын төсвөөс 640.0 сая төгрөгийг зарцуулж байна.</p>	100%	100%	
67	127	<p>Хөрөнгө гаргах тухай 2019-05-12 Дугаар 2019_192</p>	<p>2.. Эдгээр барилгын зураг төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан,</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанд “Засгийн газрын нөөцийн сангаас хөрөнгө гаргах тухай” тогтоолын төслийг танилцуулж, Улсын драмын эрдмийн театр, Дуурь бүжгийн эрдмийн театр, Үндэсний номын сангийн шинэ барилгын зураг төсөл боловсруулах 1,200.0 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн. Улсын драмын эрдмийн театрын барилгын зураг төсөл боловсруулах</p>	100%	100%	

			спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.	зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтад "Эм Эс Эл" ХХК гүйцэтгэгчээр шалгарч, гэрээ байгуулсан. Дуурь бүжгийн эрдмийн театрын барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтад "Криетив Монголиа" ХХК гүйцэтгэгчээр шалгарч, гэрээ байгуулсан. Үндэсний номын сангийн барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтад "Барилга байгууламж" ХХК шалгарч гэрээ байгуулсан.			
68	128	Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай 2019-07-03 Дугаар 2017_276	3.. Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдон гарч болзошгүй нэмэлт зардлыг 2019 оны хувьд батлагдсан төсөвт багтааж, цаашид жил бүрийн улсын төсвийн төсөлд тооцон тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	1."Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл"-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолоор батлуулсан. 2.Соёл, урлагийн ажилтны мэргэшлийн нэмэгдэл олгох заалтыг Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан. 3. Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох журмыг хэрэгжүүлэх зорилгоор соёлын ажилтанд ур чадвар болон мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулж, БСШУС-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 16/9563 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт хүргүүлсэн.3. Соёл, урлагийн ажилтны мэргэшлийн болон ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулж санал авахаар 3 дугаар сарын 14-ний өдрийн 7/1849 тоотоор Соёл, урлагийн газарт хүргүүлж, саналыг журмын төсөлд тусган боловсруулж байна.	100%	100%	

69	129	<p>Төв, суурин газрын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-07-03 Дугаар 2019_270</p>	<p>4.. Монгол Улсын Зэвсэгт хүчний анги, салбаруудын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн урсгал засварын ажил, боловсрол, соёл, эрүүл мэнд, спортын байгууллагуудын барилгын засварын ажлыг хугацаанд нь чанартай хийж дуусгах ажлыг шуурхай зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.</p>	<p>Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгөөр өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор салбарын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн урсгал засварын ажилд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 25.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 91 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна. Ажлын гүйцэтгэл 95%-тай байна.</p>	100%	100%	
70	130	<p>Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай 2019-07-03 Дугаар 2019_275</p>	<p>2.. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг баталсантай холбогдон гарч болзошгүй нэмэлт зардлыг 2019 оны хувьд батлагдсан төсөвт багтааж, цаашид жил бүрийн улсын төсвийн төсөлд тооцон тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.</p>	<p>Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор яамны төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны “Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” А/202 дугаар тушаалаар батлуулсан.</p>	100%	100%	

71	131	Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай 2019-07-03 Дугаар 2019_277	2.. Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтооход шаардагдах зардлыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны батлагдсан төсөвт багтаан зохицуулж, цаашид шаардагдах зардлыг 2020 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	2019 онд яамны нийт албан хаагчдын цалин, нэмэгдэлд ЗГ-ын тогтоолыг үндэслэн өөрчлөлт оруулж баталсан.	100%	100%	
72	132	Чингис хааны музей байгуулах тухай 2019-07-03 Дугаар 2019_280	2.. 2. Чингис хааны музейн сан хөмрөгийг бүрдүүлэх, барилгыг барьж байгуулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай: 2.1. Чингис хааны музейн ашиглалтын өмнөх захиргааг байгуулж, үйл ажиллагаанд нь энэ онд шаардагдах зардлыг 2019 оны батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлэх; 2.2. музейн үзэл баримтлал, үзүүлэлт дэглэлт зохион байгуулалтын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан батлах, музейн сан хөмрөгт Чингис хааны болон Монголын эзэнт гүрний	2.2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/458 дугаар тушаалаар Чингис хаан музейн үзэл баримтлал, үзүүлэлт дэглэлтийн төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгээс музейн үзэл баримтлалын боловсруулж бэлэн болгосон, музейн үзүүлэлт дэглэлтийн урьдчилсан төлөвлөгөөний төслийг бэлтгэж, цахим модель болгох ажлыг гүйцэтгэж байна. Түүнчлэн, гадаадын улсаас эхээр нь болон хуулбараар авах эд зүйлсийн жагсаалтыг бэлтгэж, зарим улс орнуудын музей, номын сангийн удирдлагатай яриа хэлэлцээр хийх ажлыг гүйцэтгэж байна. Тухайлбал, ОХУ-ын Эрмитаж музейгээс Чингисийн чулууны бичгийн хуулбар эхийг авах асуудлаар хэлэлцээр байгуулж, татан авах ажлыг зохион байгуулж байна. 2.3. Чингис хааны музейн шинэ барилгын зураг төслийг "Балданс" ХХК гүйцэтгэж дуусах шатандаа орж байна. Шинэ барилгын ажлыг гүйцэтгэхэд зориулж 2020 оны улсын төсөвт	100%	100%	

		<p>түүхэнд холбогдох үзмэр, эд өлгийн зүйлийг шилжүүлэн авах, шинээр бүтээх, гадаад улсын музейд хадгалагдаж байгаа түүхэн дурсгалуудыг хуулбарлан авах боломжийг судлан, зохих арга хэмжээ авах; 2.3. Байгалийн түүхийн музейн хуучин барилгыг буулгаж, тухайн газарт Чингис хааны музейн барилгын зураг төслийг боловсруулан барих, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын 2020 оны төсвийн төсөлд тусгуулах.</p>	48.7 тэрбум төгрөг батлагдсан.			
133		<p>3.. Чингис хааны музейн ашиглалтын өмнөх захиргааны үйл ажиллагааны зардлыг 2020 оноос эхлэн жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, музейн барилгыг барихад дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан нарт</p>	<p>Засгийн газрын 2019 оны 142 дугаар тогтоолын дагуу Чингис хааны өв, соёлын хүрээлэн байгуулан 2019 оны 9 дүгээр сараас үйл ажиллагааг эхлүүлсэн байна. Тус хүрээлэнгийн 2019 оны үйл ажиллагааны зардлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын батлагдсан төсвөөс гарган үйл ажиллагааг эхлүүлсэн. 2020 оны төсөвт тус хүрээлэнгийн үйл ажиллагааны зардал 921.8 сая төгрөг батлагдсан байна.</p>	100%	100%	

			тус тус даалгасугай.				
73	134	Музей нэгтгэн зохион байгуулах тухай 2019-07-03 Дугаар 2019_281	<p>2.. Музейг нэгтгэсэнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай:</p> <p>2.1. Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Үлэг гүрвэлийн төв музейн барилга болон музейн эд хөрөнгө, үзмэр, эд өлгийн зүйлсийг Байгалийн түүхийн музейд балансаас балансад шилжүүлэх ажлыг зохих журмын дагуу холбогдох байгууллагатай хамтран 2019 оны III улиралд багтаан зохион байгуулах;</p> <p>2.2. 2019 оны батлагдсан төсвийн багцдаа багтаан Байгалийн түүхийн музейн захиргаа, сан хөмрөг, бусад эд хөрөнгийг нүүлгэх ажлыг зохион байгуулж, музейн үзэл баримтлал, үзүүлэлт дэглэлтийн нарийвчилсан төлөвлөгөөг батлан үйл ажиллагааг эхлүүлэх;</p> <p>2.3. Байгалийн түүхийн музейн шинэ барилга баригдах хүртэлх хугацаанд иргэдэд үзвэрийн танхимаар үйлчлэх нөхцөлийг</p>	<p>2.1. Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/460 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгээс хоёр музейн хөрөнгө болон түүх, соёлын дурсгалт зүйлийг тоолж тулган, санхүүгийн болон хөрөнгийн холбогдох бүртгэлийг үйлдэн Төрийн өмчийн хорооны 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн "Татан буугдсан хуулийн этгээдийн эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай" 621 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлсэн.</p> <p>2.2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/495 дугаар тогтоолоор Байгалийн түүхийн музейн дүрэм бүтцийг шинэчлэн баталсан. Түүнчлэн, мөн сайдын 2019 оны А/459 дүгээр тушаалаар музейн түр үзэл баримтлал болон үзүүлэлт дэглэлтийн сэдэвчилсэн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгээс Үлэг гүрвэлийн төв музей /хуучнаар/-н байранд байгалийн үзүүлэлт дэглэх төлөвлөгөөний төслийг боловсруулаад байна. Өнөөдрийн байдлаар үзмэр дэглэх өрөө тасалгааг засварлах ажлыг гүйцэтгэж байна.</p>	100%	100%	

			бүрдүүлж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.			
74	135	Хөрөнгө гаргах тухай 2019-08-14 Дугаар 2019_326	2.. Соёл, урлагийн салбарт хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлуудыг шуурхай зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.	Байгалийн түүхийн музейн хуучин барилгыг буулгах тендерт Аяа ХХК шалгарч, ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Санхүүжилт 100 хувь олгосон. Соёл, урлагийн салбарт шинээр хийгдэж байгаа 6 бүтээн байгуулалтын барилгын эх загвар (макет)-ыг бүтээхээс Чингис хаан музей, Улсын драмын эрдмийн театр, Улсын дуурь бүжгийн эрдмийн театр, Төв номын сангийн барилгын макетыг Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр, Байгалийн түүхийн музейн шинэ барилга, Үндэсний урлагийн их театрын барилгын макетыг зураг, төсөл боловсруулах гүйцэтгэгчээр хийлгэсэн.	100%	100%
75	136	Хөрөнгө гаргах тухай 2019-08-14 Дугаар 2019_327	2.. Үзэсгэлэнгийн үйл ажиллагааг батлагдсан төсөвт багтаан, зохион байгуулалтын өндөр түвшинд төлөвлөн, зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт үүрэг болгосугай.	Монгол Улсын Ерөнхий сайдын ОХУ-д хийсэн айлчлалын үеэр үзэсгэлэнг 2020 оны хавар Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр зохион байгуулахаар тогтсон бөгөөд үзэсгэлэнд тавих үзмэрийн жагсаалтыг ОХУ-д хүргүүлээд байна. ОХУ-аас үзмэрийн жагсаалтад нэмэлт оруулах санал ирүүлээд байна. Үзэсгэлэн зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.	70%	70%
76	137	Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2019-08-14	1.. 1. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогод тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор шинжлэх ухаан,	Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилт 2020 оны улсын төсөвт 48,6 тэрбум төгрөгөөр батлагдсан нь Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын зорилтот хэмжээнд хүргэхэд үүнийг 0.32 пунктээр нэмэгдүүлэх шаардлагатай байна. Энэхүү тогтоолоор шинээр зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний	70%	70%

	Дугаар 2019_328	<p>технологийн салбарт дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай: 1.1. шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтийг төлөвлөлтийн дагуу жил бүрийн улсын төсөвт тусгах; 1.2. Шинжлэх ухаан, технологийн парк байгуулах ажлыг эрчимжүүлж, шаардагдах хөрөнгийг гадаадын зээл тусламжид хамруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.</p>	<p>байгууллагуудын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг балансаас балансад, орон тоо, төсвийн хамт шилжүүлж, дүрмийг батлуулан чиг үүргийн дагуу ажиллуулах арга хэмжээг зохион байгуулсан. Хүрээлэнгүүдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Монгол Улсад Шинжлэх ухааны парк байгуулах техник эдийн засгийн урьдчилсан судалгааг гаргасан. Судалгааны ажлууд дээр үндэслэн "Монгол Улсад Шинжлэх ухааны парк байгуулах техник, эдийн засгийн үндэслэл" боловсруулах ажлын /техникийн/ даалгаврыг боловсруулсан. Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд 2019 оны 12 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд БНХАУ-д айлчлал хийсэн айлчлалын хүрээнд зохион байгуулагдсан Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн сайд Ван Жи Ган нарын уулзалтаар Монгол Улсад Шинжлэх ухааны паркийн байгуулах нарийвчилсан төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулахад БНХАУ-тай хамтран ажиллах тохиролцоонд хүрсэн. Монгол Улсад Шинжлэх ухааны парк байгуулах ТЭЗҮ-д үндэслэн шаардагдах хөрөнгийг гадаадын зээл тусламжид хамруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана.</p>			
138		<p>4.. Энэ тогтоол гарсантай холбогдуулан өөрчлөгдөн зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний байгууллагуудын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг балансаас балансад, орон тоо, төсвийн хамт</p>	<p>1. Палеонтологи, геологийн хүрээлэн 2 тусдаа салсан. 2. Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэн Биологийн болон Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн болгож 2 салгасан. 3. Түүх, археологийн хүрээлэнг Түүх угсаатны зүйн хүрээлэн, Археологийн хүрээлэн болгож 2 салгасан. 4. Физик, технологийн хүрээлэнгийн информатикийн салбарыг, МУИС-ийн</p>	100%	100%	

			шилжүүлэн, чиг үүргийн дагуу ажиллуулах арга хэмжээг зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т тус тус даалгасугай.	Математикийн хүрээлэнтэй нэгтгэн Математик, тоон технологийн хүрээлэнг байгуулсан. Энэхүү тогтоолоор шинээр зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний байгууллагуудын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг балансаас балансад, орон тоо, төсвийн хамт шилжүүлж, дүрмийг батлуулан чиг үүргийн дагуу ажиллуулах арга хэмжээг зохион байгуулсан. Хүрээлэнгүүдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.			
77	139		2.. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт үүрэг болгосугай.	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2019 оны 12 дугаар сарын 20-нд БСШУС-ын сайдын А/827 дугаар тушаалаар баталсан. Нийт 5 зорилт 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.	70%	70%	
	140	Үндэсний хөтөлбөр батлах тухай 2019-08-21 Дугаар 2019_335	3.. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан бөгөөд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах талаар санал хүргүүлсэн.	30%	70%	

			Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.				
78	141	Олон улсын спортын наадам зохион байгуулах тухай 2019-10-09 Дугаар 2019_376	2.. Олон улсын спортын наадмыг зохион байгуулах болсонтой холбогдуулан дараахь арга хэмжээг авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай: 2.1. “Олон улсын залуучуудын спортын ногоон наадам”-ын бэлтгэл ажлыг хангах үндэсний хороог байгуулан удирдлага, зохион байгуулалтаар хангаж, тус наадмын заавар, бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг зохион байгуулах; 2.2. олон улсын спортын наадмын бэлтгэл ажлын хүрээнд шинээр барих болон засвар хийх спортын барилга байгууламж, заал, танхим, тоног төхөөрөмж, хэрэглэлээр хангах, шаардлагатай зардлын тооцоог гаргаж, улсын төсөв, гадаадын болон олон улсын байгууллагын зээл тусламжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог	"Олон улсын залуучуудын спортын ногоон наадам"-ын бэлтгэл ажлыг хангах үндэсний хороог байгуулан удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллаж байна. Бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг гарган, олон улсын спортын наадмын бэлтгэл ажлын хүрээнд шаардлагатай зардлын тооцоог гаргаж, нийт 9.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн БТСГ-ын төсөвт нэмж тусгасан.	70%	70%	

			<p>нэмэгдүүлэх замаар бүрдүүлэх; 2.3. олон улсын спортын наадмын үеэр ажиллах шүүгч, зохион байгуулагчид болон уг наадамд Монгол Улсыг төлөөлөн оролцох тамирчдын бэлтгэл, сургуулилалтыг хангах талаар холбогдох спортын холбоодтой хамтран ажиллах; 2.4. олон улсын спортын наадмын бэлтгэлийг хангах талаар хийж байгаа ажлын явцад хяналт тавьж, Засгийн газарт танилцуулж ажиллах.</p>			
79	142	<p>Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2019-10-16 Дугаар 2019_379</p>	<p>1.. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай: 1.1. Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого”-ын 4.3.3-т заасан “шинжлэх</p>	<p>Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор салбарын судалгаа боловсруулалтын ажлын орчин нөхцөлийг сайжруулах, эрдэм шинжилгээний байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, эрдэмтэн судлаачдын бүтээлийг урамшуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Шинжлэх ухаан, технологийн сангийн менежментийг боловсронгуй болгох, судалгааны ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/717 дугаар тушаалаар баталсан дэд ажлын хэсгүүд хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны</p>	30%	30%

		<p>ухаан, технологийн салбарт санхүүжилт, хөрөнгө оруулалтын олон талт эх үүсвэрийг бий болгох”- зорилтын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар улсын хэмжээнд хийгдэх бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийн судалгааны ажлыг эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлж байх журамд шилжих эрх зүйн орчин бүрдүүлэх арга хэмжээ авах; 1.2. шинжлэх ухаан, технологийн салбарын онцлогийг харгалзан эрдэм шинжилгээний ажилтанд ур чадварын нэмэгдэл болон зохих мөнгөн дэмжлэгийг сар бүр олгож байх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судлан шийдвэрлүүлэх; 1.3. “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор” барилга барих, түүний зураг төслийг боловсруулах ажлыг 2020 оноос эхлүүлэхээр тооцон төлөвлөх, хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгуулах; 1.4. олон улсад нэр хүндтэй мэргэжлийн сэтгүүлд эрдэм</p>	<p>төлөвлөгөө, санал боловсруулахаар ажиллаж байна.</p>			
--	--	--	---	--	--	--

			<p>шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн судлаачдад ур чадварын нэмэгдэл, мөнгөн урамшуулал олгож байх асуудлыг судлан шийдвэрлэх; 1.5. Шинжлэх ухаан, технологийн сан болон их сургуулиудын судалгаа-мэдээллийн санд хадгалагдаж байгаа оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг судлан, авах арга хэмжээний саналаа танилцуулах;</p> <p>1.6. Шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулах санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.</p>				
	143		<p>4.. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.</p>	<p>Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/717 дугаар тушаалаар баталсан дэд ажлын хэсгүүд хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, санал боловсруулахаар ажиллаж байна.</p>	30%	70%	
80	144	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус	<p>2.. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан үйл ажиллагаанд шаардагдах</p>	<p>Спортод допинг хэрэглэхийн эсрэг олон улсын конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд допингийн эсрэг мэдээлэл, сургалт,</p>	100%	100%	

		байгууллагаар гүйцэтгүүлэх тухай 2019-10-30 Дугаар 2019_391	зардлын төсвийг өөрийн төсвийн багцдаа зохих журмын дагуу тусгуулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.	сурталчилгаа, судалгаа хийх, урьдчилан сэргийлэх, допингийн хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн шинжилгээ авах, баталгаажуулах, үр дүнг тооцох чиг үүргийг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд тухайн байгууллагатай гэрээ байгуулсан.			
	145		4.. 4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Үлгэрчилсэн чиглэл батлах тухай” 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/119 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлах үлгэрчилсэн чиглэлийг баталсан. Энэхүү үлгэрчилсэн чиглэл нь эцэг, эх, асран хамгаалагч, олон нийттэй холбоо тогтоох, мэдээллээр хангах, тэднийг сайн дураараа, бүтээлчээр хамтран ажиллах болон тэдний санал бодлыг сонсон, аливаа шийдвэрт тусгах, хүүхдээ хөгжүүлэх ур чадвар, насан туршдаа суралцахад дэмжлэг үзүүлэх, сургуулийн үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ хийж, үр дүнг хэлэлцэн асуудлыг хамтран шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.	70%	70%	
Ерөнхий сайдын захирамж							
81	146	Гамшиг, галын аюулгүй байдлыг хангуулах талаар авах зарим арга	1.1. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын гамшиг, гал түймэр, ослын аюулаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангуулах, барилга байгууламжид тавигдах	Монгол улсын хэмжээнд гамшиг, газар хөдлөлийн гамшгаас сэргийлэх мэдлэг, мэдээлэл олгохтой зэрэгцэн Боловсролын салбарын барилга байгууламжийг өнөөгийн байдлын гамшигт тэсвэртэй байдлыг судлан боловсруулахаар Газарзүй геоэкологийн	100%	100%	

		хэмжээний тухай 2018-04-06 Дугаар 2018_68	шаардлагыг газар дээр нь шалгаж, үнэлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд нарт, дээрх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж оролцох, хамаарах нутаг дэвсгэр, салбар, байгууллагын холбогдох чиглэлийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт;	хүрээлэн, Одон орон геофизикийн хүрээлэнтэй хамтран суурь судалгааг гаргаж, анхан шатны үнэлгээг гаргаж ажилласан. Судалгааны үр дүнд 45 жилээс дээш насжилттай газар хөдлөлийн 7 баллаас дээших чичирхийллийн бүсэд байгаа сургууль, цэцэрлэг, соёл, спортын барилга байгууламжийн засвар үйлчилгээ, дахин төлөвлөлтийн талаар орон нутагтаа бодлого барьж ажиллах чиглэлийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлэн ажиллаж байна. Шинээр барьж буй барилгын чанар гүйцэтгэгч нартай холбоотой асуудлыг анхаарах зайлшгүй шаардлагатай байгаа нь барилгын насжилтаас үл хамаарсан барилгын чанар стандартыг барьж ажиллах нь чухал байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар их, дээд сургуульд "Гамшгийн менежмент" хичээлийг оруулж оюутан залуучуудад гамшиг ослын үед авран хамгаалах, өөрийгөө болон бусдыг хамгаалах чадварт суралцуулж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны "Ажлын хэсэг байгуулан удирдамж батлах тухай" А/47 тоот тушаалаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын салбарын харьяа зарим байгууллага дээр гамшгаас хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангаж, гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх үйл ажиллагааг газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргав.			
82	147	Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн	2.. Олимп, Паралимпийн наадамд бэлтгэх ажлыг сайтар хангуулан биелэлтэд хяналт тавьж, ажлын явцыг	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд-ын сайдын 2018 оны А/167 дугаар тушаалаар "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам"-ыг	100%	100%	

		<p>батлах тухай 2018-05-30 Дугаар 2018_106</p>	<p>тухай бүр танилцуулж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаад үүрэг болгосугай.</p>	<p>баталсан. Журмын дагуу шигшээ багийг спортын 16 төрлөөр нийт 160 тамирчин, 33 дасгалжуулагчтайгаар бүрдүүлэн ажиллаж байна. Олимпийн наадамд бэлтгэх Үндэсний хорооны хурлыг 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хуралдуулж 2019 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. Тус төлөвлөгөөний дагуу дараах онцлох ажлуудыг гүйцэтгэлээ: - “Токио 2020” Олимп, Паралимпийн наадамд бэлтгэж буй Үндэсний шигшээ багийн тамирчдыг дэмжих зорилгоор “Токио Олимп Сан” төрийн бус байгууллагыг байгуулсан. - Монгол Улсын баг тамирчдыг дэмжих зорилго бүхий харилцан ойлголцлын санамж бичгийг “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газартай байгуулсан. - “Токио 2020” Олимп, Паралимпийн наадамд оролцох баг тамирчид, дасгалжуулагчийн ёслолын болон спортын хувцасны загвар гаргах сонгон шалгаруулалтыг зарласан. - Үндэсний шигшээ багийн тамирчдын бэлтгэл сургуулилт, эрх авах тэмцээнүүдэд оролцуулах, бэлтгэл сургуулилт хийхэд хяналт тавин холбогдох санхүүгийн асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж байна.</p>			
83	148	<p>Их хурал зохион байгуулах тухай 2019-03-05 Дугаар 2019_25</p>	<p>2.. Их хуралд төрийн болон хувийн өмчийн бүх шатны боловсролын байгууллагын төлөөллийг бүрэн хамруулан, бэлтгэл ажлыг сайтар хангаж, үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд</p>	<p>Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор "Багш нарын VII Их хурал"-ыг “Сайн багш сайхан ирээдүй” уриан дор 2019 оны 4 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд Төрийн ордны Их танхимд амжилттай зохион байгууллаа. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/153, А/115 тоот тушаалын дагуу Багш нарын IV их хурлыг зохион байгуулах ажлын</p>	100%	100%	

			<p>Ё.Баатарбилэгт даалгасугай. хэсгийг байгуулж бэлтгэл ажлыг хангасан. Их хуралд Монголын 47.8 мянган багшийн төлөөлөл болж дээд боловсролын салбараас 108, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас 40, нийслэл болон аймаг орон нутгийн цэцэрлэг, сургуулийн багш нараас 400, мэргэжлийн холбоод, үйлдвэрчний эвлэл, олон улсын болон төр, төрийн бус байгууллагуудаас урилгаар 90 төлөөлөгч, нийт 22-91 насны 800 гаруй багш, сурган хүмүүжүүлэгч оролцож, боловсролын салбарт тулгамдаж байгаа олон асуудлын талаар хэлэлцлээ. Монголын багш нарын VII их хурлаас Боловсролын салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шийдвэрлүүлэх, Боловсролын агуулга, сургалтын бодлогыг төгөлдөржүүлэх, Багшийн хөгжил, ёс зүйн талаар болон Багшийн үнэлэмж, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр шийдвэрлүүлэх асуудал гэсэн дөрвөн хавсралт бүхий тогтоолыг гаргаж, БСШУС-ын сайдад хүргүүлсний дагуу холбогдох ажлууд хийгдэж байна. Мөн их хурлаас Монголын нийт сурган хүмүүжүүлэгчдэд хандаж долоон зүйл бүхий уриалга гаргасан. Их хурлын үр дүнд "Багшийн хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 145 дугаар тогтоол батлагдаж хэрэгжүүлж байна.</p>				
84	149	<p>Ажлын хэсэг байгуулах тухай 2019-03-05 Дугаар 2019_26</p>	<p>2.. Наймдугаар Богд Жавзандамба хутагтын мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэх тухай ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг зохион</p>	<p>Наймдугаар Богд Жавзандамба хутагтын мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган хэрэгжүүлсэн. Тус төлөвлөгөөнд тусгагдсан 12 үндсэн ажил амжилттай</p>	100%	100%	

			байгуулахыг Ажлын хэсэг (Ё.Баатарбилэг)-т даалгасугай.	хэрэгжлээ.			
85	150	Ажлын хэсэг байгуулах тухай 2019-04-16 Дугаар 2019_44	2.. Байгалийн түүхийн музей, Үндэсний урлагийн их театрын барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлын явцыг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэгт даалгасугай.	Байгалийн түүхийн музей, Чингис хаан музей, Үндэсний урлагийн их театрын барилгын зураг төсөл боловсруулах, газрын асуудлыг шийдвэрлэх, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангах талаарх мэдээллийг Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын түвшинд 6 удаа мэдээлэл хийсэн.	100%	100%	
86	151	Ажлын хэсэг байгуулах тухай / "Чингис хаан" музейн сан хөмрөгийг бүрдүүлэх, үзмэр, эд өлгийн зүйл цуглуулах, үзүүлэг дэглэлтийн ажлыг удирдан зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий / 2019-09-27 Дугаар 2019_131	2.. "Чингис хаан" музей байгуулах ажлын явц, үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлэн, гүйцэтгэлийн өндөр түвшинд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ажлын хэсэг (Ё.Баатарбилэг)-т даалгасугай.	Чингис хаан музейн дүрмийг боловсруулж батлах, хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлэх, ашиглалтын өмнөх захиргааг байгуулах, даргыг сонгож томилох зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Чингис хаан музейн үзмэр цуглуулгын төлөвлөгөөний төслийг боловсруулж бэлэн болгосны дараа уг ажлын хэсгийг хуралдуулахаар бэлтгэж байна.	70%	70%	
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
87	152	2015 оны 01 дүгээр сарын 19-н өдөр 04 дүгээр тэмдэглэл	XI. 2.2. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хороонд 65 дугаар сургуулийн 640 суудалтай, 7 дугаар хороонд	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн /1 цэцэрлэг, 21 сургууль/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус төслийн хүрээнд 1-р ээлжийн 7 сургууль, 1 цэцэрлэгийн барилга	100%	100%	

		2015-01-19 Дугаар 2015_4	67 дугаар сургуулийн 480 суудалтай, 19 дүгээр хороонд 62 дугаар сургуулийн 640 суудалтай, Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд 118 дугаар сургуулийн 320 суудалтай, 3 дугаар хороонд 18 дугаар сургуулийн 320 суудалтай, Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороонд “Шавь” цогцолбор сургуулийн 640 суудалтай, Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороонд 5 дугаар сургуулийн 300 суудалтай, Налайх дүүргийн 3 дугаар хороонд 109 дүгээр сургуулийн 640 суудалтай, Орхон аймгийн Баян-Өндөр сумын “Эрдэнэт” цогцолбор сургуулийн 960 суудалтай, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын 2 дугаар сургуулийн 320 суудалтай өргөтгөлийн барилгыг тус тус барих төсөл хэрэгжүүлэх асуудлаар БНХАУ-ын талтай тусгайлсан хэлэлцээр байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрт даалгав.	угсралтын ажлыг эхлүүлсэн байна. Үүнд: Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хороо /640 хүүхдийн сургууль/ Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хороо /920 хүүхдийн сургууль/ Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо /640 хүүхдийн сургууль/ Баянзүрх дүүргийн 19 дугаар хороо /960 хүүхдийн сургууль/ Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо /960 хүүхдийн сургууль/ Хан-Уул дүүргийн 15 дугаар хороо /920 хүүхдийн сургууль/ Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороо /640 хүүхдийн сургууль/ Архангай аймгийн Эрдэнэбулган сум /100 ортой цэцэрлэг/ барихаар 91.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр барилгын ажил эхэлсэн байна. эдгээрийн хамгийн сүүлийн барилгыг 2020 оны 3 дугаар улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.			
88	153	2015 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр 50 дугаар	ҮҮ. . Киноны тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэн дэмжээд Сангийн сайдтай хамтран баталж,	“Кино урлагийг дэмжих тухай” хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан. Мөн Хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар	100%	100%	Хяналтаас хасуулах

		тэмдэглэл 2015-09-07 Дугаар 2015_50	хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган хуулийн төслийг боловсруулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрт даалгав.	хэлэлцүүлэн 04 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан.			
89	154	2015 оны 09 дүгээр сарын 21-ны өдөр 52 дугаар тэмдэглэл 2015-09-21 Дугаар 2015_52	ҮИИ.. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг хэлэлцэн дэмжээд Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг үзэл баримтлал болон хуулийн төсөлд тусган боловсруулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Хууль зүйн сайд Д.Дорлигжав нарт даалгав.	Соёлын тухай хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд хамтран баталсан. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг төслийг боловсруулж БСШУС-ын сайдын 2019 оны 06 дугаар сарын 07-ны 1а/5215 албан бичгээр яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 9-ний хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, 2019 оны 8 дугаар сарын 16-ны өдөр УИХ-д өргөн барилаа.	100%	100%	Хяналтаас хасуулах
90	155	2016 оны 02 дугаар сарын 01-ний өдөр 07 дугаар тэмдэглэл 2016-02-01 Дугаар 2016_7	IX. 2. . Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн дүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг дор дурдсан албан тушаалтнуудад үүрэг болгов: 2.2. архивын мэргэжлийн хүний нөөцийг бакалаврын түвшинд бэлтгэх, их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт албан хэрэг хөтлөлтийн хичээлийг оруулах асуудлыг судалж	Архивын мэргэжлийн хүний нөөцийг бакалаврын түвшинд Тэнгэр дээд сургууль өдрөөр 26, эчнээгээр 117, Магистрын түвшинд 26 оюутан суралцуулж байна. Их, дээд сургуулийн хэрэгжүүлж буй хөтөлбөрт суралцагчдын албан хэрэг хөтлөлтийн чадварыг сайжруулах чиглэлд Монгол хэл бичиг, найруулга зүй (яриа, бичгийн ур чадвар) хичээл оруулж байна. Энэ хичээлийн үд дүнд эх хэлээрээ логик дэс дараалалтай, үндэслэлтэй, товч тодорхой, үнэн зөв амаар болон бичгээр өөрийгөө илэрхийлэх чадвартай болох юм. Мөн эрдэм шинжилгээний бичвэр үйлдэх, түүнд дүн шинжилгээ хийх чадвар эзэмшинэ.	100%	100%	Дотоод хяналтандаа авч ЗГХШҮМС-ийн хяналтаас хасуулах

			шийдвэрлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрт;				
91	156	2016 оны 10 дүгээр сарын 05-ний өдөр 49 дугаар тэмдэглэл 2016-10-05 Дугаар 2016_49	ХИҮ.3. . БНСУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх Байгалийн түүхийн музейн шинэ байр барих болон мэдээлэл, технологийн хамтарсан коллеж байгуулах төслүүд буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх боломжийн талаар санал боловсруулахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь нарт, Байгалийн түүхийн музейн газрын асуудлыг шийдвэрлэхийг Нийслэлийн Засаг дарга С.Батболдод;	Улаанбаатар хотноо 2016 оны 7 дугаар сарын 14-15-нд зохион байгуулагдсан Ази-Европын дээд хэмжээний уулзалтын үеэр Монгол, Солонгос хоёр улсын ерөнхийлөгч нар “БНСУ-ын буцалтгүй тусламжаар Байгалийн түүхийн музейн барилга барих төсөл” хэрэгжүүлэх асуудлыг ярилцсан. Тус яамнаас музейн шинэ барилгыг өнөөгийн байршил дээр нь барих талаарх саналаа БНСУ-ын Койка байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газраар дамжуулан тавьсан. Байгалийн түүхийн музейн өмнө нь гарсан барилга барих газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг шинэчлэн гаргуулахаар бэлтгэж байна. Зураг төслийн Балданс ХХК зураг төсвийг хийж экспертизээр баталгаажуулсан.Солонгосын буцалтгүй тусламж хэрэгжих боломжгүй болсон тул Монгол Улсын Засгийн газар улсын төсвийн хөрөнгөөр барихаар шийдвэрлэсэн. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 165 дугаар тогтоолоор Байгалийн түүхийн музейн шинэ барилгын зураг төсөл боловсруулахад шаардлагатай 400.0 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас шийдвэрлүүлсэн. мөн 2020 оны батлагдсан улсын төсөвт музей барих 94.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, үүнээс санхүүжих дүн 26.9 тэрбум төгрөг тусгасан байна.	100%	100%	
92	157	2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 36	ҮҮ.1.. Улаанбаатар хотод баригдаж байгаа болон шинээр төлөвлөгдөж байгаа	Барилга, хот байгуулалтын яам болон Нийслэлийн Засаг даргад холбогдох санал хүргүүлсэн. Сургууль цэцэрлэгийн хүрэлцээг	100%	100%	

		<p>дүгээр тэмдэглэл 2017-08-17 Дугаар 2017_36</p>	<p>хотхон, хорооллын сургууль, цэцэрлэгийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар судалгаа хийж, шаардлагатай бол холбогдох стандартыг өөрчлөх, зохих хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Г.Чулуунбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд нарт даалгав.</p>	<p>нэмэгдүүлэх хүрээнд жил бүр улсын төсөвт хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж 2017 онд 29 цэцэрлэг, 17 сургууль 2018 онд 22 цэцэрлэг, 12 сургууль ашиглалтад оруулсан байна. 2019 онд улсын хэмжээнд нийт 93 цэцэрлэг 48 сургууль ашиглалтад оруулахаар төлөвлөснөөс 12 сарын 10-ны байдлаар улсын хэмжээнд 56 цэцэрлэг, 37 сургууль үүнээс нийслэлд 4395 хүүхдийн хүчин чадалтай 25 цэцэрлэг, 10560 хүүхдийн хүчин чадалтай 20 сургуулийг ашиглалтад оруулаад байна. 2019-2020 оны хичээлийн жилд нийслэлд 3 ээлжээр хичээллэх ерөнхий боловсролын 18 сургуулийн 192 бүлгийн 7189 хүүхэд байсан. Эдгээр хүүхдүүдийг 2 ээлжид шилжүүлэх батлагдсан аргачлалын дагуу сургалтын эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан барилга байгууламжийг түрээслэн хичээл, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж, 2019-2020 оны хичээлийн жилд нийслэлд 3 ээлжээр хичээллэхгүй байхаар шийдвэрлэлээ. Байр түрээслэх зардлын тооцоог гаргаж, Сангийн яаманд албан бичгээр хүсэлт хүргүүлсний дагуу 2020 оны төсөвт ЕБС-д 1396.2 сая төгрөг, СӨБ-д 643.7 сая төгрөгийн түрээсийн зардал батлагдсан байна.</p>			
	158		<p>ХҮ1.5. 2.. Улсын хэмжээнд цэцэрлэгийн барилгын болон засварын ажлын хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгуулах, гадаадын зээл, тусламжид хамруулах замаар үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээ</p>	<p>2017 онд 29.2 тэрбум төгрөгөөр 29 цэцэрлэг ашиглалтад оруулсан бөгөөд үүнээс Япон Улсын Засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар 10 цэцэрлэг, Америкийн Нэгдсэн Улсын Номхон далайн цэргийн командлалын буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар 2 цэцэрлэгийг тус тус ашиглалтад оруулан ажилласан. 2018 онд 16.2 тэрбум төгрөгөөр 22 цэцэрлэгийг улсын болон нийслэл, дүүргийн төсвөөс санхүүжилтийг</p>	100%	100%	<p>Жил бүрийн улсын төсөвт тусгаж байгаа эсэх</p>

			<p>авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Г.Чулуунбаатарт үүрэг болгов.</p>	<p>шийдвэрлүүлсэн. 2019 онд нийт 93 цэцэрлэг ашиглалтад оруулахаар төлөвлөснөөс 12 сарын 10-ны байдлаар улсын хэмжээнд 56 цэцэрлэг, үүнээс нийслэлд 4395 хүүхдийн хүчин чадалтай 25 цэцэрлэг, ашиглалтад оруулаад байна. Мөн Улсын хэмжээнд цэцэрлэгийн их засварын ажлын хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгуулж, гүйцэтгэлийг зохион байгуулж ажилласан. 2017 онд 3 тэрбум, 2018 онд 4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгөөр шийдүүлсэн байна.</p>			
93	159	<p>2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2017-09-13 Дугаар 2017_39</p>	<p>XXXII.2. 1. 2017 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль тогтоомжийн дагуу дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчийг давуу эрхээр шалгаруулж байгааг сайшаан, цаашид дотоодын аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов.</p>	<p>Эх оронч худалдан авалтын жилийн хүрээнд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 81 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтад заасан “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ын дагуу тооцно” гэж заасныг баримтлан худалдан авах ажиллагааг зохион байгуулж, дотоодод үйлдвэрлэх боломжтой ширээ, сандал, тавилга, сурах бичиг гэх мэт ажлуудад гадаадын этгээд оролцохыг хориглосон заалт оруулан тендер шалгаруулалтыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн БСШУС-ын сайдын 2019 оны А/106 тоот "Эх оронч худалдан авалтын жил"-ийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай тушаал гарч энэ дагуу салбарын худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан. Монгол улсын хэмжээнд 2019 оны төсөвт боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад үндэсний компани болох гал тогооны тоног төхөөрөмж</p>	100%	100%	

			үйлдвэрлэдэг Чиглэл ХХК, сурагч ширээ сандал үйлдвэрлэдэг Долоон болдог ХХК-ны бүтээгдэхүүнийг давуу эрхтэйгээр сонгож байна.			
	160		XXXII.2. 2. Төсвийн болон төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа худалдан авах ажиллагааны явцын мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	Төсвийн болон төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа худалдан авах ажиллагааны явцын мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн.	100%	100%
94	161	2018 оны 3 дугаар сарын 13-ны өдөр 13 дугаар тэмдэглэл 2018-03-13 Дугаар 2018_13	ҮIII.2.. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх улирлын чанартай төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар гарган Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. 1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов: -улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор гэрээ байгуулж, төсөл, арга хэмжээний ажлыг эхлүүлэх; -эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах; -хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, тайлан мэдээг Сангийн яаманд цаг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.	70%	100%

			<p>үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор гэрээ байгуулж, төсөл, арга хэмжээний ажлыг эхлүүлэх; - эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах; -хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, тайлан мэдээг Сангийн яаманд цаг хугацаанд нь хүргүүлэх.</p>				
95	162	<p>2018 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 15 дугаар тэмдэглэл 2018-03-27 Дугаар 2018_15</p>	<p>XXIX.4. 2.. Нийслэлд шинээр баригдах сургууль, цэцэрлэгийн барилгын асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч</p>	<p>Нийслэлд шинээр баригдах сургууль, цэцэрлэгийн барилгын асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулан ажилласан.</p>	100%	100%	

			С.Батболд нарт даалгав.				
	163		XXIX.4. 3.. Нийслэл болон орон нутагт шинээр баригдах сургууль, цэцэрлэгийн барилгыг 2019 оны 9 дүгээр сард бүрэн ашиглалтад оруулахаар ажлаа төлөвлөж, зохион байгуулахыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгав.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн 21 цэцэрлэгээс 12 цэцэрлэг 2018 ондоо ашиглалтад орж, 7 цэцэрлэг нь 2019 онд ашиглалтад орж, БЗД-ийн 2-р хороонд худалдаж авах цэцэрлэг байхгүй тул хэрэгжих боломжгүй болсон ба Сэлэнгэ аймгийн Мандал суманд баригдсан цэцэрлэгийн барилга нь барилгын норм, дүрэм зөрчиж баригдсан тул ашиглалтад оруулах боломжгүй болж хасагдсан байна.	100%	100%	
96	164	2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр 16 дугаар тэмдэглэл 2018-04-04 Дугаар 2018_16	ХҮІ.9.. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны худалдан авах ажиллагааны тайлан, түүний хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнгийн талаар Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: 1. 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, тендер шалгаруулалтын явц 2018 оны I улирлын байдлаар	Засгийн газрын 2017 оны 337, 2018 оны 34 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангаж ажилласан 1.1. худалдан авах ажиллагааны цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийтлэх, тендерийн урилга, үр дүнг тухай бүр системд оруулж нээлттэй, ил тод байдлыг хангаж ажилласан; 1.2. өөрийн харьяаны 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэн хуульд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлэн ажилласан; 1.3. худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаанд багтаан зохион байгуулж, тайланг бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр тус бүрээр гаргаж тайлагнан ажилласан; 1.4. барааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн	100%	100%	Тогтмолд гардаг тэмдэглэл тул тухай бүр нт хэрэгжилтийг тооцон хяналтаас хасуулж хэвших.

		<p>“хангалтгүй” буюу 27.7 хувьтай байх тул тендер шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, Засгийн газрын 2017 оны 337, 2018 оны 34 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангаж ажиллах; 1.1. худалдан авах ажиллагааны цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийтлэх, тендерийн урилга, үр дүнг тухай бүр системд оруулж нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллах; 1.2. өөрийн харьяаны 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэн хуульд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлэх; 1.3. худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаанд багтаан зохион байгуулж, тайланг бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр тус бүрээр гаргаж тайлагнах; 1.4. барааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 101-д заасны дагуу дотоодын</p>	<p>101-д заасны дагуу дотоодын үйлдвэрээс худалдан авах, Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан.</p>			
--	--	--	---	--	--	--

			үйлдвэрээс худалдан авах, Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.				
97	165	2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2018-04-17 Дугаар 2018_17	ҮИИ.2.. Гадаад харилцаатай холбоотой асуудлаар Гадаад харилцааны яамаар, төсөв, гадаадын зээл, тусламжийн асуудлаар Сангийн яамаар холбогдох журмын дагуу дамжуулан “нэг цонхны” зарчмыг хатуу баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов.	Төсөв, гадаадын зээл, тусламжийн асуудлаар Сангийн яамаар холбогдох журмын дагуу дамжуулан “нэг цонхны” зарчмыг хатуу баримтлан ажиллаж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт гадаадын зээл, тусламжаар 2019 онд 14 төсөл арга хэмжээ хэрэгжиж байснаас 4 төсөл хэрэгжиж дууссан бөгөөд үлдсэн 10 төсөл үргэлжлэн хэрэгжихээр байна. 2020 онд эдгээр 10 төсөлд шаардагдах санхүүжилт Сангийн сайдын 2020 оны төсвийн төслийн багцад тусгасан.	100%	100%	Байнга хэрэгжүүлэх шийдвэрүүдийг дотоод хяналтандаа авч ЗГХШҮМС-ийн хяналтаас хасуулж хэвших
98	166	2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2018-05-16 Дугаар 2018_21	ХХИХ.2. 3. . Бодлогын баримт бичгийн зорилт, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга барилыг оновчтой ашиглан бодитой, хэрэгцээт мэдээллээр удирдлага, дээд шатны байгууллагыг хангахад анхаарч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг холбогдох байгууллагуудад Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хугацаанд хүргүүлсэн.	100%	100%	
99	167	2018 оны 6 дугаар сарын 13-ны өдөр 26	ХИХ.3. . Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоолоор баталсан Төрөөс	Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт туссан асуудлыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр	100%	100%	

		<p>дугаар тэмдэглэл 2018-06-13 Дугаар 2018_26</p>	<p>баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 3.1. Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт туссан асуудлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь ирүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт үүрэг болгов.</p>	<p>хийж буй ажлын үр дүнг сайжруулах, хийсэн ажлаа бүрэн тайлагнах талаар анхаарч ажиллах тухай зөвлөмжийг бүтцийн нэгжүүдэд хүргүүлсэн.</p>			
100	168	<p>2018 оны 6 дугаар сарын 27-ны өдөр 28 дугаар тэмдэглэл 2018-06-27 Дугаар 2018_28</p>	<p>IX.. “Монгол Улсад зохион байгуулах тив, олон улсын спортын тэмцээний тухай” Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 328 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан</p>	<p>Биеийн тамир, спортын тухай хуулийн 6.1.5 дахь заалтын дагуу улсын хэмжээний спортын наадмын зохицуулалттай холбоотой журмыг Засгийн газар батлахаар заасан. Үүний дагуу 2018 оны 183 дугаар тогтоолоор "Улсын хэмжээний тэмцээн, наадам зохион байгуулах журам"-ыг боловсруулан батлуулж журмын дагуу 2018, 2019 онд Монгол Улсад зохион байгуулагдах үндэсний хэмжээний спортын наадмуудыг өвөл, зуны Олимпын наадам болон олон улс, тив, дэлхийн аварга</p>	100%	100%	

			цаашид Монгол Улсад зохион байгуулах олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг олон улсын стандартад нийцсэн спортын барилга байгууламж, заал, талбай, техникийн шаардлага хангасан спортын хэрэглэл, тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй байдал болон хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг судлан үзсэний үндсэн дээр өндөр түвшинд зохион байгуулж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаад даалгав.	шалгаруулах тэмцээний давтамжтай уялдуулан зохион байгуулдаг болсон. Ингэснээр үндэсний шигшээ багийн сонгон шалгаруулалтыг шуурхай хийж, тамирчдын сургалт дасгалжуулалт тасралтгүй үргэлжилснээр Олимпийн наадамд гаргадаг амжилтаа ахиулах чухал ач холбогдолтой.			
101	169	2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл 2018-07-04 Дугаар 2018_29	Ү.. 1. Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 80 жилийн ойг 2019 онд тэмдэглэн өнгөрүүлэх тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. 2. Ахмад дайчдын гавьяа, зүтгэлийг алдаршуулан мөнхжүүлэх, залуу үеийг эх оронч үзлээр хүмүүжүүлэх болон ард иргэдийг соён гэгээрүүлэх талаар бодлого, хөтөлбөр боловсруулж 2018 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газарт оруулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, улс орны хөгжилд хувь хүн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгуулж, төрөлх эх орон, монгол хүн болж төрснөөрөө бахархах бахархлыг тээгч байх, улс орныхоо тусгаар тогтнолын баталгааг нэмэгдүүлж, түүх, соёл, шинжлэх ухааны давтагдашгүй үнэт өвийг үе дамжуулан үлдээх, байгалийн унаган төрхийг хадгалж, экосистемийн тэнцвэрт байдал болон тогтвортой хөгжлийг хангах зорилгоор Засгийн газар 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдөр "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг баталлаа. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Ой тэмдэглэх тухай" 210 дугаар тогтоолын дагуу Халхын голын байлдааны 80 жилийн ойг зохион байгуулахад Соёл, урлагийн асуудал хариуцсан	100%	100%	

			Ц.Цогзолмаад даалгав.	дэд ажлын хэсгээс хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний болон төсвийн төслийг боловсруулан Батлан хамгаалах яаманд хүргүүлээ. ОХУ-ын Гавьяат жүжигчин, П.И.Чайковскийн нэрэмжит олон улсын VI уралдааны шагналт, Гнесины нэрэмжит Московагийн хөгжмийн академийн багш С.В.Судзиловский болон түүний шавь нарын монгол оронд хийх аялан тоглолт, мастер классыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Монгол Улсын Консерватор хамтран 2019 оны 03 дугаар сард зохион байгууллаа. Ойн хүрээнд ОХУ-ын Санкт-Петербург хотноо 2019 оны 06 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд Монголын Соёлын өдрүүдийг амжилттай зохион байгууллаа.			
